

Volume 87 Number 857 March 2005

INTERNATIONAL **REVIEW** of the Red Cross

Заншлын эрх зүй



ICRC

Олон Улсын Улаан Загалмайн Сэтгүүл

Зорилго болон хамрах хүрээ

Олон Улсын Улаан Загалмайн Сэтгүүл нь Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос тогтмол эрхлэн хэвлүүлдэг сэтгүүл юм. Тус сэтгүүл нь зэвсэгт мөргөлдөөний болон бусад хамтарсан зэвсэгт хүчирхийллийн нөхцөл байдал үйл ажиллагааны тухай болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тусгал, бодлогыг дэмжих зорилготой. Хүмүүнлэгийн эрх зүйн чиглэлээр тусгайлан гардаг сэтгүүл болохын хувьд үндсэн эрх болон үнэт зүйлсийг хамгаалж байдаг хэм хэмжээг зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулах, эрх зүйн хөгжил болон шүүмжлэлт дүн шинжилгээ, мэдлэгийг хөхиүлэн дэмжихийг зорьдог юм. Тус сэтгүүл нь орчин үеийн хүмүүнлэгийн үйл ажиллагааны талаар хэлэлцүүлэг явуулах төдийгүй мөргөлдөөний мөн чанар, шалтгааны талаар дүн шинжилгээ хийснээр тэдгээрээс үүдэн гарах хүмүүнлэгийн бэрхшээлүүдийн талаар тодорхой ойлголт өгдөг. Эцэст нь тус сэтгүүл нь Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо, ялангуяа ОУУЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэгч тэргүүлэх сэтгүүл юм.

Олон Улсын Улаан Загалмайн Хороо

Олон Улсын Улаан Загалмайн Хороо (ОУУЗХ) нь дотоодын хүчирхийлэл болон дайнд хохирогчдын амь нас, нэр хүндийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх хүмүүнлэгийн чиг үүрэг бүхий шударга, төвийг сахисан, бие даасан байгууллага юм. ОУУЗХ нь Мөргөлдөөний үед Хөдөлгөөнөөс хэрэгжүүлдэг олон улсын тусламжийн үйл ажиллагааг удирдан зохицуулдаг. Мөн олон улсын хүмүүнлэгийн эрх зүй болон хүмүүнлэгийн түгээмэл зарчмуудыг дэмжиж, хөгжүүлснээр зовлон зүдгүүрээс урьдчилан сэргийлэхийг хичээдэг. 1863 онд байгуулагдсан ОУУЗХ нь Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгийг үндэслэгч нь юм.

Хорооны Гишүүд

Ерөнхийлөгч: Якоб Келленбергер
Дэд Ерөнхийлөгч: Анн Петипьер
Байнгын Дэд Ерөнхийлөгч: Жак Форстер

Жан Абт
Жан-Филипп Ассаль
Кристин Библи
Паоло Бернаскони
Эрнст А. Бруггер
Сузи Брушвайлер
Жан де Куртен
Паола Гилани

Клод Ле Кутр
Жак Морейон
Габриелла Наншен
Ив Сандо
Даниел Тюрер
Оливье Водо
Андре фон Мос

Олон Улсын Улаан Загалмайн Сэтгүүл

Ерөнхий редактор
Тони Пфаннер ОУУЗХ

Редакцийн зөвлөл
Ахмед Абу Эл-Вафа
Кайрогийн Их Сургууль, Египет

Даниел Бар-Тал
Тел Авиын Их Сургууль, Израйел

Аннет Бекер
Парисын Их Сургууль, Франц

Антонио Канкадо Триндад
Бразилын Их Сургууль, Бразил

Марика Фален
Гадаад Хэргийн Яам, Стокхолм, Швед улс

Бернард Хейкел
Нью-Йоркийн Их Сургууль, АНУ

В.С. Мани
Гужарахын Хуулийн Их Сургууль,
Гандхинагар, Гужарах, Энэтхэг Улс

Херфрид Мюньклер
Хамболдын Их Сургууль, Берлин, Герман
Улс

Мона Ришмави
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний
Эрхийн Дээд Комиссар, Женев

Элизабет Салмон Гарате
Перугийн Понтификака Католик Их Сургууль,
Лима, Перу

Марко Сассоли
Женевын Их Сургууль, Швейцарь

Майкл Н.Шмитт
Жорж С.Маршалын нэрэмжит Аюулгүй
Байдал Судлалын Европын Төв, Гармиш
Партенкирхэн, Герман

Теренс Тэйлор
Стратеги Судлалын Олон Улсын Институт,
Лондон/Вашингтон ДиСи, ИБ/АНУ

Бахтияр Р. Тузмухамедов
Дипломат Академи, Москва, Оросын
Холбооны Улс

Вен-чи Джу
Хуулийн Сургууль, БНХАУ-ын Ренминын Их
Сургууль, Бээжин, Бүгд Найрамдах Хятад
Ард Улс

Заншлын эрх зүй

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын талаар хийсэн судалгаа: Зэвсэгт мөргөлдөөний эрх зүйн тухай ойлголт, түүнийг хүндэтгэн сахихад хувь нэмэр оруулах нь

Жан-Мари Хэнкертс¹

Жан-Мари Хэнкертс нь Олон Улсын Улаан Загалмайн Хорооны хуулийн хэлтэст хуулийн зөвлөх бөгөөд ОУУЗХ-ны олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын судалгааны тэргүүнээр ажилладаг. Тэрээр саяхан Cambridge University Press-т хэвлэгдсэн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын тухай судалгааны хоёр ботийг Луиз Досвальд-Бекийн хамт хянан тохиолдуулжээ.

Товч агуулга

Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооны олон улсын бага хурлаас гаргасан шийдвэрт үндэслэн ОУУЗХ-ноос хийсэн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын тухай судалгааны агуулга, үндэслэгээг тайлбарласан өгүүлэл юм. Судалгааны бүтэц

¹ Зохиогчийн зүгээс энэ өгүүллийг бэлтгэхэд туслалцаа үзүүлсэн Эрик Монгэлард, мөн олон чухал зөвөлгөө өгсөн Луиз Досвальд-Бек болон Хуулийн Хэлтсийн хамт олондоо талархал илэрхийлж байна. Энэ өгүүллийн үзэл санаа нь зохиогчийн үзэл бодол бөгөөд ОУУЗХ-ны үзэл бодлыг заавал тусгасан байх албагүй болно.

болон судалгааг хийхэд ашигласан арга зүй, судалгааны гол дүгнэлтүүдийг энэ өгүүлэлд хураангуйлан тайлбарласан боловч судалгааны үр дүн болон дүн шинжилгээний талаар бүрэн тусгаагүй болно.

Танилцуулга

Хүн төрөлхтөн 50 жилийн хугацаанд буюу 1949 оны Женевын конвенц батлагдсанаас хойш бараг бүх тивийг хамарсан түгшүүрийн харанга дэлдэхүйц олон тооны зэвсэгт мөргөлдөөнийг туулж өнгөрөөлөө. Энэ хугацаанд Женевын дөрвөн конвенц болон тэдгээрийн 1977 оны нэмэлт протоколууд дайтах ажиллагаанд шууд оролцоогүй эсхүл оролцохоо больсон хүмүүсийг (шархдагсад, өвчтөн, хөлөг онгоц нь сүйрсэн, зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой шалтгаанаар эрх чөлөө нь хасагдсан хүмүүс болон энгийн иргэд) эрх зүйн хамгаалалтаар хангаж ирсэн. Гэсэн хэдий ч эдгээр гэрээг зөрчих явдал цөөнгүй байдаг нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг илүүтэй хүндэтгэн сахиж байсан бол зайлсхийж болох байсан үхэл хагацал, зовлон зүдгүүрийн шалтгаан болсон юм.

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчил гарч буй нь түүний дүрэм журам хангалтгүй байсантай биш харин эдгээр дүрэм журмыг хүндэтгэн сахиыхыг хүсэхгүй байгаа болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам хангалтгүй байгаа, зарим тохиолдолд дүрэм журмыг хэрхэн хэрэглэх нь тодорхойгүй, улс төрийн удирдагчид, цэргийн дарга нар, байлдаж буй хүмүүс ба олон нийт энэ талаар мэдлэг багатай байгаагаас үүдэлтэй гэсэн ерөнхий үзэл баримтлал байна.

1993 оны 8-9-р сард Женевт хуралдсан Дайны Хохирогчдыг Хамгаалах тухай Олон Улсын Бага Хурлаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлийг арилгах арга замын талаар тухайлан хэлэлцсэн боловч шинээр гэрээний зүйл заалт нэмэх санал гаргаагүй. Түүний оронд бүх нийтийн зөвшилцлөөр баталсан Эцсийн Тунхаглалд “хүмүүнлэгийн эрх зүйн хэрэгжилтийг илүү үр дүнтэй болгох шаардлагатай байгаа” тухай дахин батлаад, “Засгийн газар хоорондын мэргэжилтний нээлттэй бүлэг томилж хүмүүнлэгийн эрх зүйг дагаж мөрдөх, дээдлэх явдлыг хөхиүлэн дэмжих бодит арга замыг судлуулах, Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбооны олон улсын дараагийн бага хуралд илтгэл бэлтгэж танилцуулахыг” Швейцарын Засгийн

газарт даалгасан.²

Дайнд Хохирогчдыг хамгаалах Засгийн газар хоорондын бүлэг 1995 оны 1 дүгээр сард Женевт хуралдаж олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хөхиүлэн дэмжих, ялангуяа хууль хэрэгжүүлэх, мэдлэг дээшлүүлэхэд чиглэгдсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай цуврал зөвлөмж баталсан. Засгийн газар хоорондын мэргэжилтнүүдийн бүлгийн II дугаар зөвлөмжид:

Өөр хоорондоо ялгаа бүхий олон эрх зүйн систем болон газар зүйн олон бүсийн төлөөллийг оролцуулсан ОУХЭЗ (олон улсын хүмүүнлэгийн эрх зүй)-н мэргэжилтнүүдийн тусламж, Засгийн газрууд болон олон улсын байгууллагуудтай зөвшилцөн олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээний тухай илтгэл бэлтгэж, холбогдох улс орон, эрх бүхий олон улсын байгууллагуудад түгээхийг Олон улсын улаан загалмайн хорооноос хүссэн.³

1995 оны 12 сард Улаан Загалмай Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн 26-р бага хурлаар энэ зөвлөмжийг баталгаажуулж, олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд холбогдох олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээний талаар илтгэл бэлтгэхийг Олон Улсын Улаан Загалмайн Хороонд үүрэг болгосон.⁴ Тэр цагаас хойш бараг арван жилийн дараа буюу 2005 онд өргөн хүрээний судалгаа шинжилгээ хийж, эрдэмтэн мэргэжилтнүүд удаан хугацаанд зөвлөлдсөний эцэст олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээний судалгаа гэгдэх энэхүү тайлан хэвлэгдсэн юм.

Зорилго

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын судалгааны зорилго нь Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээг хэрэглэхэд тулгардаг

² Дайнд Хохирогчдыг Хамгаалах Тухай Олон Улсын Бага Хурал, Женев, 8 дугаар сарын 30-аас 9 дүгээр сарын 1 1993 он, Төгсгөлийн Тунхаглал, International Review of the Red Cross, № 296, 1993, х.381

³ Дайнд Хохирогчдыг Хамгаалах Засгийн Газар Хоорондын Мэргэжилтнүүдийн Бүлгийн Уулзалт, Женев, 1-р сарын 23-27, 1995, зөвлөмж II, international Review of the Red Cross, № 310, 1996 он, х.,84.

⁴ Улаан загалмай Улаан хавирган сар нийгэмлэгийн 26-р бага хурал, Женев хот, 12 дугаар сарын 3-4, 1995 он, 1-р тогтоол, Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй: Хуулиас үйл ажиллагааны зүг; Дайнд хохирогчдыг хамгаалах тухай Олон улсын бага хурлын дараах үйл ажиллагааны тайлан, International Review of the Red Cross, Дугаар. 310, 1996, х. 58.

бэрхшээлийг шийдвэрлэхэд оршино.

Гэрээний эрх зүй сайн хөгжсөн бөгөөд дайны үед тодорхой хэсэг бүлэг хүмүүсийг хамгаалах, дайнд хэрэглэж болох арга замыг хязгаарлаж дайны олон асуудлыг хамаарч зохицуулдаг. Женевын конвенцууд болон тэдгээрийн нэмэлт протоколуудаар дайн тулалдаанд оролцоогүй буюу шууд оролцохгүй байгаа хүмүүсийг өргөн хүрээнд хамгаалах механизм бүрэлдсэн. Дайны арга хэрэгслийг зохицуулдаг гэрээний эрх зүй бүр 1886 оны Санкт Петербургийн Тунхаглал, 1899 ба 1907 оны Гаагийн тогтоомжууд 1925 оны Хийн тухай Женевын конвенцуудаас эхтэй бөгөөд 1972 оны Биологийн Зэвсгийн тухай конвенц, түүний 1977 оны нэмэлт Протоколууд, 1980 оны Тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох тухай конвенц болон түүний таван Протоколууд, Химийн Зэвсгийн тухай 1993 оны конвенц, Хүний Эсрэг Мина Хэрэглэхийг Хориглох тухай 1997 оны Оттавагийн конвенц зэргээр зохицуулагдаж байна. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах асуудлыг 1954 оны Гаагийн конвенц болон түүний хоёр Протоколоор нарийн зохицуулдаг. 1998 оны Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрэмд тус шүүхийн харьяалалд хамаарах дайны гэмт хэргүүдийг жагсаасан байдаг.

Гэсэн хэдий ч орчин үеийн зэвсэгт мөргөлдөөний үед эдгээр гэрээг хэрэглэхэд үндсэн хоёр бэрхшээл тулгардаг учраас олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээний судалгаа хийх зайлшгүй шаардлагатай байсан юм. Эхнийх нь, дээрх гэрээнүүд зөвхөн соёрхон баталсан улс орнуудад л үйлчилдэгт оршдог. Энэ нь оролцогч улсууд аль гэрээг соёрхон баталснаас шалтгаалан зэвсэгт мөргөлдөөнүүдийн үед өөр өөр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээ үйлчилнэ гэсэн үг юм. 1949 оны Женевын дөрвөн конвенцийг бүх нийтээр соёрхон баталсан бол олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бусад гэрээнүүдийн хувьд тийм биш. Жишээ нь тэдгээрийн нэмэлт Протоколууд байна. Нэмэлт I Протоколыг одоогийн байдлаар 160 гаруй улс орон соёрхон баталсан боловч олон улсын зэвсэгт мөргөлөөнд оролцож буй хэд хэдэн улс тус Протоколыг батлаагүй учир түүний үр нөлөө нь хязгаарлагдмал байна. Нэмэлт II Протоколын хувьд ч ялгаагүй бараг 160 гаруй улс орон соёрхон баталсан боловч олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцож буй зарим улс орнууд соёрхон батлаагүй хэвээр байна. Эдгээр олон улсын бус шинж чанартай

зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулж буй олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн цорын ганц гэрээний зүйл заалт нь Женевын дөрвөн конвенцын нийтлэг 3 дугаар зүйл юм. Тийм учраас судалгааны ажлын эхний зорилт нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн аль хэм хэмжээ нь олон улсын эрх зүйн заншил болсон гэдгийг олж тогтоох явдал бөгөөд ингэснээрээ тухайн мөргөлдөөнд оролцогч бүх талууд энэ хэм хэмжээг болон ойролцоо агуулга бүхий дүрэм журмыг агуулсан гэрээ хэлэлцээрийг соёрхон баталсан эсэхээс үл хамааран дагаж мөрдөх үүрэгтэй болох юм.

Хоёрдугаарт, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээгээр өнөөгийн зэвсэгт мөргөлдөөний ихэнх хэсгийг буюу олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнийг хангалттай сайн зохицуулж чадахгүй байна. Энэхүү олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулж буй олон улсын гэрээний хэм хэмжээ нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнтэй харьцуулахад хамаагүй цөөн байдагтай холбоотой. Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд цөөн хэдэн гэрээ үйлчилдэг бөгөөд, тодруулбал Тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох тухай конвенц, Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм, Хүний эсрэг мина хэрэглэхийг хориглох тухай Оттавагийн конвенц, Химийн зэвсэгийн тухай конвенц, Соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенц болон түүний Нэмэлт II Протокол, мөн дээр дурдсанчлан Женевын дөрвөн конвенцын нийтлэг 3 дугаар зүйл болон Нэмэлт II Протокол зэрэг орно. Хэдийгээр нийтлэг 3 дугаар зүйлийн ач холбогдол их боловч хамгийн энгийн доод стандартуудыг тогтоож өгсөн. Нэмэлт II Протоколын хувьд нийтлэг 3 дугаар зүйлийг дэлгэрүүлж өгсөн боловч Женевын конвенцууд Нэмэлт I Протоколоор зохицуулагдаж буй олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хамаарах дүрэм журамтай харьцуулахад төдийлөн хангалттай дэлгэрэнгүй болж чадаагүй.

Нэмэлт II Протокол зөвхөн 15 зүйлээс бүрддэг бол Нэмэлт I Протокол 80 гаруй зүйлтэй. Тоонд тулгуурлан дүгнэлт хийх нь өрөөсгөл боловч олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний гэрээний зохицуулалт, ялангуяа нарийвчилсан зохицуулалт, тодорхойлолтын хувьд маш их ялгаатай болох нь дээрхээс харагдаж байна. Судалгааны хоёрдахь зорилт нь олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээгээр олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнийг гэрээний эрх зүйгээс илүү нарийн

зохицуулж байгаа эсэх, тийм бол хэрхэн зохицуулж байгаа талаар олж мэдэх явдал юм.

Арга зүй

Олон улсын шүүхийн дүрэмд олон улсын эрх зүйн заншлыг “эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий практик”⁵ гэжээ. Олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг бий болсон эсэхийг тогтооход улс орнуудын практик (*usus*) болон тухайн практик нь холбогдох дүрэм журмын мөн чанараас хамаарч хориглох, зөвшөөрөх, шаардах хуулийн мөн чанартай (*opinio juris sive necessitatis*) болохыг хүлээн зөвшөөрсөн байх гэсэн үндсэн хоёр элемент байх ёстойг нийтээр хүлээн зөвшөөрдөг. Олон улсын шүүх Эх газрын хормойн тухай (*Continental Shelf case*) хэрэгт гаргасан шийдвэртээ “Олон улсын заншлын эрх зүй бий болсон эсэхийг тогтооход юун түрүүнд улс орнуудын *opinio juris* болон бодит практикийг харгалзан үзэх нь тодорхой юм”⁶ гэжээ. Эдгээр хоёр элементийн утга, агуулгын талаар судалгааны ажил олонтаа хийгдэж байсан. Судалгааны явцад олон улсын заншлын эрх зүй бий болсон эсэхийг тогтооходоо уламжлалт арга буюу Олон улсын шүүхээс тогтоосон аргуудыг хэрэглэсэн. Ялангуяа Хойд далайн Эх газрын хормойн тухай хэрэг⁷ хэрэглэсэн аргуудыг ашигласан.

Улс орны практик

Улс орны практикийг хоёр өнцгөөс харах ёстой: Нэгдүгээрт, олон улсын заншлын эрх зүй бүрэлдэн бий болоход нөлөөлдөг практикийг олж тогтоох (улс орны практикийг сонгох); хоёрдугаарт энэ практик нь олон улсын заншлын хэм хэмжээг бий болгож байгаа эсэхийг тогтоох зэрэг орно.

Улс орны практикийг сонгох

Олон улсын заншлын эрх зүй бүрэлдэн бий болоход улс орны хүсэл зоригийн илэрхийлэл ба үйлдлүүд нөлөөлдөг. Үйлдэл

⁵ Олон улсын шүүхийн дүрэм, 38(1)(b) дугаар зүйл

⁶ Олон улсын шүүх, Эх газрын хормойн тухай хэрэг (*Libyan Arab Jamahiriya v. Malta*), Шүүхийн шийдвэр, 6 дугаар сарын 3, 1985 он, ОУШ-ийн Тайлан 1985 он, х 29-30, § 27.

⁷ Олон улсын шүүх, Хойд далайн эх газрын хормойн тухай хэрэг, Шүүхийн шийдвэр, 2 дугаар сарын 20, 1969, ОУШ-ийн Тайлан 1969 он, х 3.

гэдэгт жишээлбэл, дайны талбарт хийсэн үйлдэл, ямар төрлийн зэр зэвсэг хэрэглэсэн, ямар хүмүүстэй хэрхэн харьцсан зэргийг оруулж ойлгоно. Хүсэл зоригийн илэрхийлэл гэдэгт цэргийн гарын авлага, үндэсний хууль тогтоомж, үндэсний шүүхийн шийдвэр, зэвсэгт хүчин болон аюулгүйн хүчинд өгсөн зааварчилгаа, дайны үеийн цэргийн мэдэгдэл, дипломат шугамаар хийсэн эсэргүүцэл, албан ёсны хуулийн зөвлөхийн үзэл бодол, олон улсын гэрээний төсөлд улс орнуудын өгсөн санал, гүйцэтгэх засаглалаас гаргасан шийдвэр, дүрэм, журам, Олон улсын шүүхэд явагдсан мэтгэлцээн, олон улсын уулзалтын үеэр хийсэн мэдэгдэл, олон улсын байгууллагын тогтоолын талаар Засгийн газруудын байр суурь зэрэг орно. Дээрх жагсаалтаас үзэхэд улс орны гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглалын практик нь олон улсын заншлын эрх зүй бүрэлдэхэд нөлөөлдөг болох нь харагдана.

Олон улсын байгууллага эсвэл олон улсын бага хурлаас баталсан тогтоол, түүнийг хэлэлцсэн байдал, санал хураалтын тухай тайлбар зэрэг нь улс орнуудын үйлдэлд багтана. Зарим нэг тохиолдлыг эс тооцвол дээрх тогтоолуудыг заавал биелэгдэх шинжтэй бус гэж үздэг учраас олон улсын заншлын эрх зүйг бий болоход аливаа тогтоол хэрхэн нөлөөлснийг тогтооход түүний агуулга, хүлээн зөвшөөрөгдсөн цар хүрээ, уг тогтоолтой холбогдсон улс орнуудын практикийг харгалзан үздэг. Тухайн тогтоолыг илүү хүлээн зөвшөөрч, дэмжиж байвал түүний ач холбогдол ч мөн өсдөг.

Олон улсын шүүхийн шийдвэрүүд нь Олон улсын шүүхийн туслах чанарын эх сурвалжид тооцогддог ч улс орны практик биш юм. Учир нь үндэсний шүүхээс ялгаатай нь, Олон улсын шүүхүүд төрийн байгууллага биш байдаг оршдог. Гэсэн хэдий ч олон улсын заншлын хэм хэмжээ байгааг тогтоосон Олон улсын шүүхүүдийн шийдвэр нь заншлын хэм хэмжээ бий болсныг нотолж байдаг. Мөн түүнчлэн, Олон улсын шүүхүүдийн шийдвэр нь улс орнууд болон олон улсын байгууллагын практикт нөлөөлснөөр олон улсын заншлын эрх зүй бий болоход хувь нэмэр оруулдаг.

Ёс зүйн дүрэм, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тодорхой дүрэм журмыг дагаж мөрдөхөө баталсан амлалтууд болон бусад төрлийн мэдэгдлүүд зэрэг зэвсэгт эсэргүүцлийн бүлгийн практикууд нь улс орны практик болж чадахгүй. Хэдийгээр эдгээр практик нь олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний тодорхой дүрэм журмыг хүлээн зөвшөөрсний баталгаа мөн боловч эрх

зүйн ач холбогдол нь тодорхойгүйн улмаас олон улсын заншлын хэм хэмжээ байгаа эсэхийг тогтооход ач холбогдол багатай юм. Ийм практикийн жагсаалтыг судалгааны хоёрдугаар ботид “бусад практикууд” гэсэн нэрийн дор оруулсан байна.

Улс орны практикийг үнэлэх

Олон улсын заншлын хэм хэмжээг бий болгоход улс орны практик хангалттай “нөлөө үзүүлж” буй эсэхийг тогтоохын тулд үнэлэх хэрэгтэй болдог.⁸ Олон улсын заншлын эрх зүйг бий болгохын тулд улс орны практик нь бараг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн, өргөн хүрээг хамарч төлөөлсөн байх хэрэгтэй.⁹ Энэ юу гэсэн үг болох тухай илүү дэлгэрүүлж үзэцгээе.

Нэгдүгээрт, улс орны практик олон улсын заншлын хэм хэмжээг үүсгэхэд бараг бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Улс орнууд өөр өөр практиктай байж болохгүй. Олон улсын шүүх аль нэг улс өөр практиктай байгаа нь өнгөц харахад бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байх шаардлагыг хангахгүй байгаа мэт харагдаж болох ч буруутай үйлдлийг нь бусад улсууд буруушаасан эсвэл Засгийн газар нь өөрөө буруу болохыг хүлээн зөвшөөрсөн бол олон улсын заншлын хэм хэмжээ бүрэлдэн бий болоход нөлөөлөхгүй гэж үзсэн байна. Иймэрхүү зэмлэн буруушаасан болон буруу болохыг хүлээн зөвшөөрсөн явдал нь маргаантай байсан хэм хэмжээг бататгаж өгдөг.

Олонхи улс орнууд хүлээн зөвшөөрсөн ч зарим нэг улс орон удаа дараа зөрчиж байсан олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээний хувьд энэ нь илүү хамаатай юм. Зөрчил гаргасны дараа буруугаа хүлээж уучлал гуйсан, холбогдох талууд уучилсан эсвэл бусад улс орнууд тухайн үйлдлийг буруушаасан бол тухайн заншлын хэм хэмжээ бий эсэхийг тогтооход сөргөөр нөлөөлөхгүй юм. Хэдийнээ оршин буй олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээг өөрчлөх хүсэлтэй улс орнууд албан ёсны практик, үйлдээрээ үүнийгээ харуулж, өөрийн зөв болохыг нотлох ёстой болдог.

Хоёрдугаарт, ердийн олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэхэд улс орны холбогдох практик нь өргөн хүрээг хамарсан

⁸ “dense” гэдэг үгийг энэ утгаар нь дараах номноос авлаа. Sir Humphrey Waldock, “General Course on Public International Law”, Collected Courses of the Hague Academy of International Law, Vol. 106, 1962, p. 44.

⁹ Олон улсын шүүх, Хойд далайн эх газрын хормойн тухай хэрэг, op. cit. (note 7), p. 43, § 74.

болон төлөөлөлтэй байх ёстой байдаг. Харин бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байх шаардлагагүй бөгөөд “ерөнхий” практик л тогтсон байхад хангалттай юм.¹⁰ Тодорхой хувь эсвэл тооны улс орон хүлээн зөвшөөрсөн байх шаардлага байхгүй. Хүлээн зөвшөөрөхулс орнуудын хувьд тодорхой тоон шаардлага тогтоохгүй байх нэг шалтгаан нь энэ нь угаасаа тоон биш харин чанарын шаардлага байдагт оршдог. Өөрөөр хэлбэл асуудлын гол нь зөвхөн хэдэн улсын практикт хэрэглэгдэж байгаад бус ямар улс орнууд хэрэглэж байгаад юм.¹¹ Хойд далайн эх газрын хормойн тухай хэрэгт Олон улсын шүүх үзэхдээ тухайн практик нь “ялангуяа ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдөж байгаа улс орнуудыг хамарсан байх” ёстой гэсэн байна.¹²

Энэ үзэл баримтлал нь хоёр үр дагавартай: (1) хэрэв “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдсөн” бүх улсын практикт хэрэглэгдэж буй бол ихэнх улс орнууд практиктаа дагаж мөрддөг байх зайлшгүй шаардлага байхгүй бөгөөд зөвхөн “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдөж байгаа” улс орнуудын практикийг хүлээн зөвшөөрсөн төдийгөөр хангалттай гэж үздэг; (2) хэдийгээр нийтээр зөвшөөрсөн байх шаардлага тавигддаггүй ч хэрэв “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдсөн улс” хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол тухайн практик олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ болох боломжгүй болно.¹³ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд ямар улсыг “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдсөн” улс гэж үзэх вэ гэдэг нь нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй байна. Жишээ нь: Нүд сохлогч лазерын зэвсэгийг хэрэглэх нь хууль ёсны болох эсэх асуудлын хувьд “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдсөн улс” гэдэгт бусад улс орон тэдгээр зэвсэгээс болж хохирох боломжтой эсэхээс үл хамааран ийм төрлийн зэвсэг хийж байгаа улс орнуудыг хамруулж үздэг. Үүний нэгэн адил, “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдсөн” улс гэдэгт хүмүүнлэгийн тусламж авах хэрэгцээтэй байгаа улс орнууд болон хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг улс орнуудыг мөн

¹⁰ Олон улсын эрх зүйн холбоо, Олон улсын эрх зүйн зарчим (ерөнхий) хэрхэн бүрэлдэх тухай судлах комиссын эцсийн тайлан, Олон улсын эрх зүйн ерөнхий зарчим бий болоход нөлөөлдөг зарчмуудын тухай мэдэгдэл, 68 дугаар бага хурлын тайлан, Лондон хот, 2000 он, 14-р зарчим, х. 734 (Цаашид “ОУЭЗХ-ны Тайлан гэх”).

¹¹ Ibid., 14-х зарчмын тайлбар (d) ба (e), хх. 736-737.

¹² Олон улсын шүүх, Хойд далайн эх газрын хормойн тухай хэрэг, op. cit. (тэмдэглэл 7), х. 43, § 74.

¹³ ОУЭЗХ-ны тайлан, op. cit. (тэмдэглэл 13), 14-р зарчмын тайлбар (e), х. 737.

хамруулж ойлгоно. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн аливаа хэм хэмжээний хувьд зэвсэгт мөргөлдөөнд оролцогч улсын практикийг тухайн зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдуулан шалгах үед “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгддөг”. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тодорхой асуудлаар тусгайлан эрх ашиг нь хөндөгдсөн улс орон байж болох ч бүх улс орон мөргөлдөөнд оролцогч эсэхээс үл хамааран бусад улс оронд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэхийг шаардах эрх зүйн сонирхолтой байдаг.¹⁴ Түүнчлэн, бүх улс орон бусад улсын өдөөсөн дайн, дайны арга хэрэгслээс болж хохирох боломжтой юм. Тийм учраас, энэ нэр томъёог явцуу утгаар нь ойлговол “ашиг сонирхол нь хөндөгдсөн” эсэхээс үл хамааран бүх улс орны практикийг авч үзэх ёстой.

Эрх зүйн үүднээс олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээтэй холбогдуулан “бүрэн эсэргүүцэгч” улс байж болох эсэх талаар судалгаанд дурдаагүй байна. Олон судлаачид *jus cogens*-ын хувьд байнга татгалзагч гэж байх боломжгүй гэж үздэг бол зарим нь ерөөсөө бүрэн эсэргүүцэгчийн тухай ойлголт одоо хүртэл хүчин төгөлдөр гэдэгт эрэлзсэн байдаг.¹⁵ Хэрэв аль нэг улс эрх зүйн хувьд бүрэн эсэргүүцэгч байж болно гэж хүлээн зөвшөөрч байгаа бол тухайн улс уг хэм хэмжээг шинээр бүрэлдэж буй цагаас эхлээд эсэргүүцэж, эсэргүүцлээ цаашид үргэлжлүүлсээр байх ёстой; “бий болсон хойно нь эсэргүүцэгч” гэсэн ойлголт байж болохгүй юм.¹⁶

Олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ бүрэлдэн бий болох хүртэл тодорхой хугацаа шаарддаг боловч тусгайлан тогтоосон хугацаа байдаггүй. Харин гол шийдвэрлэх шаардлагууд болох төлөөлөл, хамрах хүрээ, нэгдмэл байдал зэрэгт тулгуурлан хангалттай практик тогтсон эсэхээс хамаардаг.

Opinio juris

Олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ үүссэн эсэхийг тоогтооход тавигдах *opinio juris*-ын шаардлага гэдэг нь тодорхой практик нь “зөв”, хуулийн дагуу явагдсан гэдгийг эрх зүйн үүднээс нотлох

¹⁴ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээ-г үз, *op. cit.* (тэмдэглэл 4), боть 1, 144-р тайлбар.

¹⁵ Энэ асуудлын талаар дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл, Maurice H. Mendelson-г үз, “The Formation of Customary International Law”⁸ *Collected Courses of the Hague Academy of International Law*, Vol. 272, 1998, pp. 227-244.

¹⁶ ОУЭЗХ-ны Тайлан, *op. cit.* (тэмдэглэл 13), 15-р зарчмын тайлбар (b), х. 738.

явдал юм. Холбогдох заншлын хэм хэмжээ нь хориглосон, үүрэг болгосон, эсвэл зүгээр эрх олгосон хэм хэмжээ эсэхээс хамаарч тухайн практик болон түүнийг хууль зүйн баталгааны илрэх хэлбэр нь ялгаатай байна.

Судалгаа хийх явцад цэвэр практикийн элемент болон хууль зүйн баталгааны хооронд тодорхой ялгаж зааглах нь маш хэцүү бөгөөд ихэвчлэн онолын асуудал болох нь харагдсан. Ихэвчлэн хууль зүйн баталгаа болон практик нь нэг л актад тусгагдсан байдаг. Олон улсын эрх зүйн холбооноос тэмдэглэн хэлэхдээ Олон улсын шүүх “эдгээр нь заншлын эрх зүйд хоёр тусдаа элемент боловч нэг үйлдлээр энэ хоёрыг илэрхийлэх боломжгүй гэж огт дурьдаагүй төдийгүй ихэнх тохиолдолд энэ хоёр элементийг тусад нь ойлгоход хэцүү бөгөөд салгах боломжгүй байдаг” гэжээ.¹⁷ Энэ нь ялангуяа тухайн улсын практик болон хууль зүйн баталгаа ч болж байдаг цэргийн заавар зэрэг амаар өгсөн үүрэгт хамаатай юм.

Хангалттай практик бүрдсэн гэж үзэх үед *opinio juris* нь тухайн практикт ихэвчлэн тусгагдсан байдаг учраас *opinio juris* байгаа гэдгийг тусгайлан батлах шаардлага гардаггүй. Харин практик нь тодорхойгүй, эргэлзээтэй байгаа үед тухайн практик нь заншлын хэм хэмжээ үүсэхэд нөлөөлөх эсэхийг тогтооход *opinio juris* чухал үүрэгтэй. Улс орон ямар нэг үйлдэл буюу хариу үйлдэл хийхгүй байгаа үед *opinio juris* чухал байдаг бөгөөд яагаад гэдэг нь тодорхойгүй юм. Ийм тохиолдлуудад Олон улсын шүүх болон түүнээс урьд оршиж байсан Олон улсын шударга ёсны байнгын шүүхийн аль аль нь олон улсын заншлын эрх зүй бүрэлдсэн эсэхийг тогтооход улс орнуудын эргэлзээтэй практикийг хэрэглэх асуудлыг шийдэхийн тулд *opinio juris*-ыг тусад нь салгаж үзэж байсан.¹⁸

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн салбарт тодорхой үйлдэл хийхийг цээрлэхтэй холбоотой олон зохицуулалт байдаг бөгөөд тухайн үйлдлээс татгалзсан явдал нь хуулийг хүндэтгэсэн, эсвэл

¹⁷ Ibid., p. 7188 § 10(c). Энэ асуудлыг гүнзгийрүүлэн харахыг хүсвэл, Peter Haggemacher-г үз, “La doctrine des deux elements du droit coutumier dans la pratique de la Cour Internationale”, *Revue generale de droit international public*, Vol. 90, 1986, p. 5.

¹⁸ Олон улсын шударга усны байнгын шүүх, *Lous case* (France v. Turkey), Шүүхийн шийдвэр, 9 дүгээр сарын 7, 1927 он, PCIJ Ser. A, No. 10, p. 28 (Улс орнууд усан онгоцны тавцан дээр үйлдэгдсэн буруу үйлдлийн төлөө шүүн таслах үйл ажиллагаа явуулах эрхгүй гэж үзсэн учраас шүүх үйл ажиллагаа явуулаагүй болохыг шүүх тогтоосон); Олон Улсын Шүүх, *North Sea Continental Shelf cases*, op. cit. (note 7), pp 43-44, § 76-77 (Улс орнууд тэгш орон зайн зарчимд тулгуурлан эх газрын хормойн хилээ тогтоохоор тогтсон байсан улс орнууд өөрсдийн хүлээн үүргийн улмаас тийнхүү тогтоож чадаагүй болохыг шүүх олж тогтоосон); ОУЭЗХ-ны Тайлан, op. cit. (тэмдэглэл 13), 17-р зарчмын тайлбар.

зүгээр л тохиолдол байсан эсэхийг тогтоох хэрэгтэй болдог учир *opinio juris*-ыг үнэлэхэд тодорхой бэрхшээлүүд тулгардаг. Тодорхой үйлдлээс татгалзах тухай зүйл заалт олон улсын баримт бичиг болон албан ёсны мэдэгдэлд байвал тухайн үйлдлийг үйлдэхээс цээрлэх тухай хуулийн шаардлагыг хангасан гэж үзнэ. Түүнчлэн, мөн тухайн асуудлаар маргаантай байдал үүссэний дараа үйлдэл хийхээс татгалзах нь энэ нь тохиолдлын үйлдэл биш байсныг харуулах боловч ямар нэг хуулиар хүлээсэн үүргийн дагуу хийсэн гэдгийг нотлох нь амаргүй юм.

Гэрээний эрх зүйн үр нөлөө

Гэрээ нь улс гүрнүүд олон улсын эрх зүйн тодорхой хэм хэмжээг хэрхэн ойлгож хүлээн авч байгааг харуулдаг учир олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг байгааг тогтооход ач холбогдолтой байдаг. Тийм ч учраас олон улсын гэрээг соёрхон батлах, гэрээний хэрэгжилт, гэрээг тайлбарлах, соёрхон батлах үедээ гэрээнд тайлбар хийх тухай судалгаанд тусгасан. Олон улсын шүүх Хойд далайн эх газрын хормойн хэрэгт олон улсын эрх зүйн заншлыг үнэлэхэд гэрээг соёрхон баталсан байдлыг харгалзан үзсэн нь илт харагддаг. Шүүх энэ талаар “одоогийн байдлаар соёрхон баталсан болон нэгдэн орсон улс орнууд (39) цөөнгүй байгаа боловч хангалттай бус байна” гээд ялангуяа гэрээнд нэгдэн ороогүй улс орнуудын практик өөр байгааг тэмдэглэсэн байна.¹⁹ Nicaragua-ийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх хэм хэмжээний заншлын статусыг тогтооходоо Нэгдсэн үндэстний байгууллагын дүрмийг бараг бүх нийтээр соёрхон баталсан гэдэгт шүүх их ач холбогдол өгч байсан.²⁰ Ашиг сонирхол тусгайлан хөндөгдсөн улс орнуудыг оруулаад адил төстэй практикийг хэрэглэж буй тохиолдол хангалттай байгаа үед олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон эсэхээс үл хамааран түүний зүйл заалт нь заншлын хэм хэмжээний тусгал болох нь байдаг ба ийм хэм хэмжээг эсэргүүцэх нь ховор байдаг.²¹

¹⁹ Олон Улсын Шүүх, North Sea Continental Shelf cases, *op. cit.* (note 7), p. 42, § 73.

²⁰ Олон Улсын Шүүх, Case concerning Military and Paramilitary Activities in and against Nicaragua, *op. cit.* (тэмдэглэл 12), pp. 99-1008 § 188. Шүүх шийдвэрээ гаргахад нөлөөлсөн өөр нэг гол нөхцөл нь нийтээр хүлээн зөвшөөрсөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолууд, тухайлбал санал хураалгүйгээр баталсан Улс орнуудын хоорондын найрсаг харилцааны тухай 2625 (XXV) дугаар тогтоол байсан.

Бодит байдал дээр гэрээний төсөл боловсруулах нь дэлхийн эрх зүйн үзэл санааг тухайн асуудал дээр төвлөрүүлэхээс гадна улс орнуудын цаашид хийх үйлдэлд нөлөөлж, хууль зүйн үзэл сэтгэлгээг төлөвшүүлэхэд эргэлзээгүй ач холбогдолтой юм. Олон улсын шүүх Continental Shelf –ийн хэрэгт “олон талт конвенц нь заншлаас үүссэн хэм хэмжээг тогтоох, тодорхойлох эсвэл тэдгээрийг цаашид хөгжүүлэхэд чухал үүрэгтэй” гэж үзжээ.²² Ийнхүү Шүүх гэрээ нь урьд нь оршиж байсан олон улсын эрх зүйн заншлыг төрөлжүүлэн эмхэтгэхээс гадна гэрээнд байгаа хэм хэмжээнд үндэслэн шинэ заншлын хэм хэмжээ бий болох суурийг тавьж өгдөг болохыг баталсан юм. Шүүх цааш нь “ашиг сонирхол нь тусгайлан хөндөгдөж бйагаа улс орнуудыг оролцуулаад маш өргөн хүрээний төлөөлөл бүхий оролцогчдоос бүрдэх конвенц дангаараа ... хангалттай юм” гэжээ.²³

Судалгаанд гэрээг өргөн хүрээнд соёрхон баталсан явдал нь зөвхөн илрэл төдий бөгөөд тухайн гэрээнд нэгдэж ороогүй улс орнуудын практик болон бусад элементүүдтэй харьцуулан цогц байдлаар үнэлэх ёстой гэж үзээд нэлээд болгоомжтой байр суурнаас хандсан. Гэрээнд нэгдэн ороогүй улс орнуудын эерэг практикт чухал ач холбогдол өгсөн байдаг. Түүнчлэн, гэрээнд нэгдэн ороогүй улс орнуудын эсрэг практикт ч мөн адил сөрөг нотолгоо гэж үзэн ач холбогдол өгсөн. Гэрээнд нэгдэн орсон улс орнуудын болон нэгдэн ороогүй улс орнуудын практикийн хоорондын харьцааг мөн чухалчилж үзсэн.

Тийм учраас судалгаа нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн холбогдох гэрээнд нэгдэн ороогүй улс орнуудаар практик төдийгөөр хязгаарлагдаагүй болно. Жишээ нь: Зөвхөн нэмэлт протоколуудыг соёрхон батлаагүй 30 улс орны практикийг судлах төдийгээр судалгааг хязгаарлах нь олон улсын эрх зүйн заншил өргөн хүрээг хамарсан төлөөлөлтэй байх гэсэн шаардлагад нийцэхгүй болох байсан. Тийм учраас заншлын эрх зүй байгаа эсэхийг тогтоохдоо

²¹ Олон Улсын Шүүх, Continental Shelf case, op. cit. (note 6), p.33, § 34. (Далайн Эрх Зүйн тухай НҮБ-ын конвенц хүчин төгөлдөр болоогүй байсан ч эдийн Засгийн онцгой бүсийн тухай ойлголт хэдийн олон улсын заншлын эрх зүйн нэг хэсэг болсон гэж шүүх үзсэн. Учир нь онцгой эдийн Засгийн бүсээ зарласан улсын тоо 56-д хүрч, тэдний дунд ашиг сонирхол нь хөндөгсөн улс хэд хэд байсан байна.)

²² Олон Улсын Шүүх, Continental Shelf case, op. cit. (тэмдэглэл 6), pp. 29-30, § 27.

²³ Олон Улсын Шүүх, North Sea Continental Shelf cases, op. cit. (тэмдэглэл 7), p. 42, § 73; мөн ОУЭЗХ-ны тайланг үзнэ үү. op. cit. (тэмдэглэл 13), 20-21, 24, 26 болон 27-р зарчмууд, pp. 754-765.

энэ судалгааг хэвлэгдэх үед Нэмэлт I Протоколыг соёрхон баталсан 162 улс, Нэмэлт II Протоколыг соёрхон баталсан 157 улсыг анхаарч үзсэн болно.

Энэ судалгаагаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээний хэм хэмжээ бүрийн заншлын эрх зүй мөн эсэхийг тогтоохыг зориогүй учраас одоо үйлчилж буй гэрээнүүдийн бүтцийг дагаж мөрдөөгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Харин тодорхой асуудалтай холбоотой улс орнуудын практикт үндэслэн олон улсын эрх зүйн заншлын ямар хэм хэмжээг байгааг олж тогтоохын тулд нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Гэрээ бүрийн зүйл заалтыг заншил мөн эсэхэд дүн шинжилгээ хийх тал дээр судалгааны арга маань чиглэгдээгүй учраас судалгаанд дурдагдаагүй гэдэг үндэслэлээр аль нэг гэрээний хэм хэмжээг заншил биш гэж дүгнэж болохгүй.

Судалгааны бүтэц, зохион байгуулалт

ОУУЗХ-нд даалгасан үүрийг биелүүлэх хамгийн зохистой замыг олохын тулд зохиогчид олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр мэргэшсэн хэсэг эрдэмтэдтэй зөвлөлдөж тухайн судалгааны Удирдах Зөвлөлийг байгуулсан.²⁴ Удирдах Зөвлөлөөс 1996 оны 6 дугаар сард үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр боловсруулснаар судалгааны ажил тухайн оны 10 дугаар сард эхэлсэн. Улс орнуудын практикийг тусгасан үндэсний болон олон улсын эх сурвалжид тулгуурлан судалгааг хийхдээ үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан судалгааны зургаан хэсэгт төвлөрч ажилласан:

- Ялгаж үзэх зарчим
- Онцгойлон хамгаалагдах хүмүүс болон объектууд
- Дайны тусгай арга хэрэгсэлүүд
- Зэвсэг
- Жагсаалаас гарсан хүмүүс болон энгийн иргэдтэй харьцах
- Хэрэгжилт

Үндэсний эх сурвалжид хийсэн судалгаа

Үндэсний эх сурвалжийг тухайн улсын дотоодоос олоход хялбар учраас үндэсний судлаачидтай хамтарч ажиллахаар шийдсэн. Энэ

²⁴ Удирдах Зөвлөл нь профессор Georges Abi –Saab, Salah El-Din Amer, Ove Bring, Eric David, John Dugard, Florentino Feliciano, Horst Fischer, Françoise Hampson, Theodor Meron, Djamchid Montaz, Milan Sahovic болон Raul Emilio Vinuesa нараас бүрдэж байв.

зорилгоор 50 орчим улс оронд (Африкт 9, Америкт 11, Азид 15, Австралид 1, Европт 11) нэг буюу хэд хэдэн судлаачид багтахбаг бүрдүүлж өөрийн улсын холбогдох практиктын талаар тайлан бичихийг хүссэн.²⁵ Улс орнуудыг сонгохдоо газар зүйн төлөөллийг үндэслэсэнээс гадна сүүлийн үед олон төрлийн дайны арга хэрэгсэл хэрэглэсэн зэвсэгт мөргөлдөөнд оролцож байсан эсэхийг харгалзаж үзсэн.

Улс орнуудын практикийн талаархи илтгэлд тусгагдаагүй улсын цэргийн гарын авлага болон үндэсний хууль тогтоомжуудыг цуглуулж судалсан болно. Энэ ажлыг хийхэд дэлхий даяар сүлжээ бүхий ОУУЗХ-ны төлөөлөгчдийн газрын сүлжээ болон ОУУЗХ-ны Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөвөлгөө өгөх үйлчилгээний дагуу цуглуулсан үндэсний эрх зүйн цуглуулгыг ашигласан.

Олон улсын эх сурвалжид хийсэн судалгаа

Судалгааны ажлын хэсэг бүрт хуваагдан ажиллаж байсан зургаан баг олон улсын эх сурвалжаас улс орны практикийг цуглуулах ажлыг хийсэн.²⁶ Эдгээр багууд Нэгдсэн үндэстний байгууллага болон Африкийн Холбоо (хуучнаар Африкийн Эв Нэгдлийн Байгууллага), Европын Зөвлөл, Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөл, Европын холбоо, Арабын орнуудын холбоо, Америкийн орнуудын байгууллага, Лалын бага хурлын байгууллага, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага зэрэг бусад олон улсын байгууллагын хүрээн дэхь практикийг судалсан. Мөн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээ байгааг нотлоход ач холбогдол бүхий олон улсын хэргүүдийг цуглуулсан.

²⁵ Африк: Алжир, Ангол, Боцван, Египит, Итоп, Нигер, Рванда, Өмнөд Африк болон Зинбабве; Америк: Аргентин, Бразил, Канад, Чили, Колумб, Куба, Эл Салвадор, Никарагуа, Перу, Америкын Нэгдсэн Улс болон Уругвай; Азид: БНХАУ, Энэтхэг, Индонез, Иран, Ирак, Израйл, Япон, Жордан, БНСУ, Кувейт, Лебанон, Малайз, Пакистан, Филиппин болон Сир; Австрали: Австрали; Европ: Белги, Босни Херцоговина, Хорват, Франц, Герман, Итали, Недерланд, Оросын Холбооны Улс, Испани, Нэгдсэн Вант Улс болон Югослав.

²⁶ Ялгаатай байдлын Зарчим: Профессор Georges Adi-Saab (илтгэгч) болон Jean-Francois Quegnier (судлаач); Тусгайлан хамгаалагдах хүмүүс болон объектууд: Профессор Horst Fischer (илтгэгч), Gregor Schotten болон Heike Spieker (судлаач); Дайны тусгай арга хэрэгсэл: Профессор Theodor Meron (илтгэгч) болон Richard Desgagne (судлаач); Зэр зэвсэг: Профессор Ove Bring (илтгэгч) болон Gustaf Lind (судлаач); Hors de combat хүмүүс болон энгийн иргэдтэй харьцах: Профессор Françoise Hampson (илтгэгч) болон Camille Giffard (судлаач); Хэрэгжилт: Профессор Eric David (илтгэгч) болон Richard Desgagne (судлаач).

Олон Улсын Улаан Загалмайн Хорооны архивт хийсэн судалгаа

Олон улсын болон үндэсний эх сурвалжуудад хийсэн судалгаанд нэмэр болгож ОУУЗХ-ны өөрийнх нь архивт байсан сүүлийн үед гарсан ойролцоогоор 40 орчим зэвсэгт мөргөлдөөний (Африкт 21, Америкт 8, Азид 8, Европт 8) материалтай танилцсан.²⁷ Эдгээр мөргөлдөөнийг сонгосноор улс орнуудын практикийн илтгэлд тусгагдаагүй улсууд болон мөргөлдөөнийг орхигдуулаагүй болно. Үндэсний, олон улсын болон ОУУЗХ-ны гэсэн гурван эх сурвалжийг хамтатгасны үр дүнд дэлхийн өнцөг булан бүрээс улс орны практикийг тусгах боломжийг олгосон. Энэ нь судалгааны ажил бүрэн дууссан гэсэн үг биш юм. Орчин үеийн олон улсын эрх зүйн заншлыг тодорхой болгох үүднээс судалгаа нь сүүлийн 30 жилийн улс орнуудын практикт чиглсэн боловч шаардлагатай үед холбогдох эртний практикаас ч иш татсан.

Мэргэжилтнүүдийн зөвөлгөө

Зөвөлгөөний эхний шатанд ОУУЗХ-оос олон улсын судалгааны багийг урьж цугларсан практикт үндэслэн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын үнэлгээг урьдчилсан байдлаар тусгасан хураангуй товчлол хийхийг хүссэн. Хураангуйг 1998 онд Женевт болсон Удирдах зөвлөлийн гурван удаагийн уулзалтаар авч хэлэлцсэн. Хураангуйг сайтар хянасны эцэст зөвөлгөөний хоёрдах шатанд дэлхийн өнцөг булан бүрээс оролцсон эрдэмтэд болон ЗЗасгийн газрын мэргэжилтнүүдийн бүлэгт шилжүүлэн өгсөн. Хувь хүнийх нь чадварт тулгуурлан ОУУЗХ-оос сонгосон эдгээр мэргэжилтнүүдийг 1999 онд Женевт болсон Удирдах Зөвлөлийн хуралд урьж оролцуулсан бөгөөд хурлын үеэр цугларсан практикийг үнэлэх, мөн тусгагдаагүй орхигдсон практикийн талаар санал дүгнэлт гаргах зэргээр хурлын үйл ажиллагаанд оролцсон.²⁸

²⁷ Африк: Ангол, Бурунд, Чад, Чад-Либяа, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Джибути, Эритриа-Емэн, Этоп (1973-1994), Либери, Мозанбек, Намиб, Нигер-Камерон, Рванда, Синегал, Синегал-Мауритан, Сирилеон, Сомал, Сомал-Этоп, Судан, Уганда болон Баруун Сахар; Америк: Гуатемал ба Мексик; Ази: Афганистан, Кампуч, Энэтхэг (Жамму ба Кашмир), Папа Нью Гуин, Шри Ланк, Тажикистан, Имен ба Имен-Эритриа (Африкийн доор мөн орох); Европ: Армен-Азарбайжан (Нгорно-Карабах), Кипрус, Хуучин Югослав (Югославт гарсан хямрал (1992-1995), Босниа ба Хэрцэговин (1992-1996), Хорватын хямрал (Кражинас) (1992-1995)), Гүрж (Абхазиа), Оросын Холбооны Улс (Чечень) болон Турк улс.

Тайланг бичсэн нь

Удирдах Хорооны дүгнэлтийг эрдэмтэд ба Засгийн газрын мэргэжилтнүүдийн бүлгээс хянасаар судалгааны эцсийн илтгэлийг бичих ажлын суурь тавигдсан. Практикийг дахин шалгаж, заншлын хэм хэмжээ байгаа эсэхийг дахин үнэлж, хэм хэмжээ хэрхэн бүрэлдсэнийг хянасны дараа тайлбарын төслийг бичсэн. Эдгээр төслийн бичвэрийн талаар санал авахаар Удирдах зөвлөл, эрдэмтэд ба Засгийн газруудаас томилсон мэргэжилтнүүдийн бүлэг, ОУУЗХ-ны хуулийн хэлтэст илгээсэн. Хүлээн авсан санал зөвөлгөөг тусгаснаар агуулгыг эцсийн байдлаар баталсан.

Судалгааны хураангуй

Нийтлэг 3 дугаар зүйлийг оруулаад Женевын конвенцын зүйл заалтуудын дийлэнх олонхи нь олон улсын заншлын эрх зүйд хамаарна гэж үздэг. Женевын конвенцид одоогоор 192 улс орон нэгдэн ороод байгааг харгалзан үзвэл энэ гэрээ нь бараг бүх улс орны хувьд заавал биелэгдэх шинжтэй юм. Тиймээс заншлын хэм хэмжээ гэж хэлж болохоор эдгээр конвенцуудын зүйл заалтуудыг судалсангүй. Харин гэрээгээр зохицуулагдаж байгаа ч бүх нийтээр соёрхон батлаагүй асуудлуудыг, ялангуяа Нэмэлт Протоколууд, Соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Гаагийн конвенц болон зэвсэгийн хэрэглээг зохицуулдаг хэд хэдэн тодорхой конвенцуудад анхаарлаа хандуулсан.

Доор дурдагдах олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг яагаад заншлын хэм хэмжээ гэж үзэх болсон болон ийм дүгнэлтэд хүрэх болсон үндэслэл болох улс орны практикийн талаар тайлбарлахыг зорьсонгүй. Яагаад тухайн хэм хэмжээг заншлын хэм хэмжээ гэж үзэх болсон тухай судалгааны 1 дүгээр ботиос, харин улс орны холбогдох практикийн талаар 2 дугаар ботиос үзэх боломжтой юм.

²⁸ Дараах эрдэмтэд болон Засгийн газрын мэргэжилтнүүд энэ зөвөлгөөнд оролцсон: Abdallah Ad-Douri (Ирак), Paul Bergan (Нэгдсэн Вант Улс), Sadi Caucu (Турк), Micheal Cowling (Өмнөд Африк), Edward Cummings (Америкийн Нэгдсэн Улс), Antonio de Icaza (Мексик), Yoram Dinstein (Израил), Jean-Michel Favre (Франц), William Fenrick (Канад), Dieter Fleck (Герман), Juan Carlos Gomez Ramirez (Колумб), Jamshed A. Hamid (Пакистан), Arturo Hernandez Basave (Мексик), Ibrahim Idriss (Этопиа), Hassan Kassem Jouni (Лебанон), Kenneth Keith (Шинэ Зеланд), Githu Muigai (Кэнн), Rein Mullerson (Эстон), Bara Niang (Сенегал), Mohamed Olwan (Иордан), Raul C. Pangalangan (Филиппин), Stelios Perrakis (Грек), Paulo Sergio Pinheiro (Бразил), Arpad Prandler (Унгар), Permmaraju Sreenivasa Rao (Энэтхэг), Camilo Reyes Rodriguez (Колумб), Itse E. Sagay (Нигер), Harold Sandolval (Колумб), Somboon Sangianbut (Тайланд), Marat A. Sarsembayev (Казакстан), Muhammad Aziz Shukri (Сир), Parlaungan Sihombing (Индонез), Geoffrey James Skillen (Австрали), Guoshun Sun (Хятад), Bakhtyar Tuzmukhamedov (Оросын Холбооны Улс), болон Karol Wolfke (Польш).

Олон Улсын Зэвсэгт Мөргөлдөөн

Нэмэлт I Протокол урьд нь оршиж байсан олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээг эмхэтгэснээс гадна шинэ заншлын хэм хэмжээ бүрэлдэх үндэс суурийг тавьсан. Судалгааны хүрээнд цуглуулсан улс орны практикаас үзэхэд Нэмэлт I Протоколын улс орнуудад үзүүлсэн нөлөө нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнөөс гадна олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд ч нөлөөлсөн нь илт болсон юм (доор үз). Түүнчлэн Нэмэлт I Протоколын үндсэн зарчмууд нь уг протоколыг соёрхон баталсан орны тооноос хамаагүй өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн болох нь тодорхой болсон.

Хэдийгээр судалгааны үр дүнд тодорхой гэрээний зүйл заалт бүр нь заншлын шинжтэй эсэхийг тогтоохыг зориогүй боловч гэрээний эрх зүйд байдагтай ижил төстэй олон заншил байдаг болох нь судалгааны явцад илэрхий болсон. Нэмэлт I Протоколд тусгагдсан заншлын хэм хэмжээнүүдээс жишээ дурдвал: Энгийн иргэд ба байлдагч, болон иргэний байгууламж болон цэргийн байгууламжийн хооронд ялгаатай хандах зарчим;²⁹ нэлд нь устгах довтолгооныг хориглох;³⁰ довтолгооны үед пропорциональ байдлын зарчмыг харгалзах;³¹ довтолох үедээ болон довтолгооны үр дагаврын эсрэг бололцоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэг;³² эмнэлгийн ба шашны ажилтан, эмнэлгийн нэгж болон тээврийг хүндэтгэх, хамгаалах үүрэг;³³ хүмүүнлэгийн тусламжийн ажилтан болон байгууламж,³⁴ сэтгүүлч энгийн иргэн;³⁵ эмнэлгийн үүрэгтнийг хамгаалах үүрэг;³⁶ хамгаалалтгүй орон нутгийн байгууламж болон цэрэг зэвсэггүй бүс рүү довтолохыг хориглох;³⁷ жагсаалаас гарсан дайсныг хамгаалах, орон байраар хангах үүрэг;³⁸ өлсгөлөнг хориглох;³⁹ энгийн хүн амын амьжиргаанд зайлшгүй шаардлагатай байгууламж руу довтолохыг хориглох;⁴⁰ ялгах тэмдгийг буруу болон хуурамчаар хэрэглэхийг хориглох;⁴¹ жагсаалаас гарсан хүмүүс болон энгийн иргэдэд үндсэн баталгаагаар хангах үүрэг;⁴² сураггүй алга болсон хүмүүсийн талаар мэдээлэл өгөх үүрэг;⁴³ болон

²⁹ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн Заншил-г үз, op. cit. (тэмдэглэл 4), 1-р боть, 1, 7-р Дүрэм

³⁰ Мөн тэнд., 11-13-р Дүрэм

³¹ Мөн тэнд., 14-р Дүрэм

³³ Мөн тэнд., 25 ба 27-30-р Дүрэм

³² Мөн тэнд., 15-24-р Дүрэм

³⁴ Мөн тэнд., 31-32-р Дүрэм

³⁵ Мөн тэнд., 34-р Дүрэм

³⁶ Мөн тэнд., 26-р Дүрэм

³⁷ Мөн тэнд., 36-37-р Дүрэм

³⁸ Мөн тэнд., 46-48-р Дүрэм

эмэгтэйчүүд, хүүхдэд олгох тусгай хамгаалалт⁴⁴ зэрэг юм.

Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн

Энэ төрлийн мөргөлдөөнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа нь сүүлийн хэдэн арван жилд хуримтлагдсан практикаас харагдаж байна. Энэ практикууд олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хамаарах заншлын хэм хэмжээ бүрэлдэхэд чухал үр нөлөө үзүүлсэн. Нэмэлт I Протоколын нэгэн адил Нэмэлт II Протокол дээрх практикт хүчтэй нөлөөлсний үр дүнд эдүгээ тус протоколын олон зүйл заалтыг олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ гэж үзэх болсон. Нэмэлт II Протоколд тусгагдсан заншлын хэм хэмжээг дурдвал: Энгийн иргэдийг довтлохоос хамгаалах;⁴⁵ эмнэлгийн ба шашны ажилтан, эмнэлгийн нэгж ба тээврийг хүндэтгэн хамгаалах үүрэг;⁴⁶ эмчлэх үүргээ биелүүлж байгаа хүмүүсийг хамгаалах үүрэг;⁴⁷ өлсгөлөнг дайтах арга ажиллагаа болгохыг хориглох; ⁴⁸ энгийн хүн амын аж төрөхөд зайлшгүй шаардлагатай байгууламж руу довтлохыг хориглох;⁴⁹ жагсаалаас гарсан иргэд болон энгийн хүмүүсийн fundamental guarantees үндсэн баталгааг хүндэтгэх үүрэг;⁵⁰ шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг хамгаалах, хүндэтгэх, эрж хайх үүрэг;⁵¹ нас барагсдыг эрж хайх, цогцсыг нь хамгаалах үүрэг;⁵² эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээдийг хамгаалах үүрэг;⁵³ энгийн иргэдийг хүчээр нүүлгэхийг хориглох;⁵⁴ болон эмэгтэйчүүд, хүүхдэд олгох тусгай хамгаалалт⁵⁵ зэрэг юм.

Гэсэн хэдий ч Нэмэлт II Протоколоос илүүтэйгээр дотоодын зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулдаг нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын эрх зүйн оруулсан гол хувь нэмэр юм. Нэмэлт II Протоколын ерөнхий зүйл заалтуудыг бодвол илүү дэлгэрэнгүй заншлын хэм хэмжээ бий болсон нь дотоодын мөргөлдөөний

³⁹ Мөн тэнд., 53-р Дүрэм

⁴⁰ Мөн тэнд., 54-р Дүрэм

⁴² Мөн тэнд., 87-105-р Дүрэм

⁴⁴ Мөн тэнд., 134-137-р Дүрэм

⁴⁶ Мөн тэнд., 25, болон 27-30-р Дүрэм

⁴⁸ Мөн тэнд., 53-р Дүрэм

⁵⁰ Мөн тэнд., 87-105-р Дүрэм

⁵² Мөн тэнд., 112-113-р Дүрэм

⁵⁴ Мөн тэнд., 129-р Дүрэм

⁴⁰ Мөн тэнд., 54-р Дүрэм

⁴¹ Мөн тэнд., 57-65-р Дүрэм

⁴³ Мөн тэнд., 117-р Дүрэм

⁴⁵ Мөн тэнд., 1-р Дүрэм

⁴⁷ Мөн тэнд., 26-р Дүрэм

⁴⁹ Мөн тэнд., 54-р Дүрэм

⁵¹ Мөн тэнд., 109-111-р Дүрэм

⁵³ Мөн тэнд., 118-119, 121, 125-р Дүрэм

⁵⁵ Мөн тэнд., 134-137-р Дүрэм

зохицуулалтын цоорхойг нөхсөн юм.

Жишээ нь: Нэмэлт II Протоколд дайн тулалдааны талаар зөвхөн энгийн тойм зохицуулалт байдаг. 13-р зүйлд “дайтах ажиллагаанд шууд оролцоогүй бол ... энгийн хүн ам, иргэдийн эсрэг довтлохгүй” гэж заажээ. Нэмэлт I Протоколоос ялгаатай нь Нэмэлт II Протокол ялгаатай хандах болон порпорциональ байдлын зарчмын талаар тодорхой дүрэм журам, тодорхойлолт агуулдаггүй.

Нэмэлт II Протоколын дайн байдлааны тухай зохицуулалтын цоорхойг улс орнуудын практикаар ихэнхийг нь нөхсөн ба Нэмэлт I Протоколд байдагтай төстэй зохицуулалтууд бий болсон ч тэдгээр нь олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний үед заншлын эрх зүйн үүднээс үйлчилдэг. Эдгээрт дайн дайтах ажиллагааны үндсэн зарчмууд, тусгайлан хамгаалагдах хүмүүсийн тухай дүрэм журам, дайн тулалдааны объектууд болон арга хэрэгсэл зэрэг багтана.⁵⁶

Мөн Нэмэлт II Протоколд энгийн хүн амын хэрэгцээнд зориулсан хүмүүнлэгийн тусламжийн талаар маш ерөнхий зүйл тусгасан байдаг. 18(2)-р зүйлд “Энгийн хүн ам амжиргааны зайлшгүй чухал зүйлээр гачигдаж байгаа үед... хүмүүнлэг бөгөөд энэрэнгүй байх зарчмын дагуу ялгаварлан гадуурхахгүйгээр тусламжийг хэрэгжүүлнэ” гэжээ. Хэдийгээр 18(2)-р зүйлд тусгагдсан гэж маргаж болох ч Нэмэлт I Протоколоос ялгаатай нь Нэмэлт II Протоколд хүмүүнлэгийн тусламжийн ажилтан ба объектыг хүндэтгэх, хамгаалах, хүмүүнлэгийн тусламжийг хэрэгцээтэй байгаа иргэдэд шуурхай, саадгүй хүргэх боломжоор хангах, зөвшөөрөл бүхий хүмүүнлэгийн тусламжийн ажилтныг чөлөөтэй зорчих боломжоор хангах зэрэг шаардлагыг сөргөлдөж буй талуудад тавьсан тодорхой заалтууд байдаггүй. Эдгээр шаардлага нь өргөн хүрээг хамарсан төлөөлөлтэй бараг л бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн практик болж чадсан учир олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний аль алинд нь хэрэглэгдэх олон улсын эрх зүйн заншил болон төлөвшсөн юм.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэх хэрэгтэй нэг зүйл бол Нэмэлт I, II

⁵⁶ Мөн тэнд., 7-10-р Дүрэм (иргэний байгууламж болон цэргийн байгууламжийн хоорондын ялгаа), 11-13-р Дүрэм (ялгалгүй довтлох), 14-р Дүрэм (довтолгооны пропорциональ байдал), 15-21 Дүрэм (довтлох үед сэргийлэх зүйлс), 22-24-р Дүрэм (довтолгооны үр нөлөөний эсрэг урьдчилан сэргийлэх), 31-32-р Дүрэм (хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажилтан болон объект); 34-р Дүрэм (иргэний сэтгүүлч); 35-37-р Дүрэм (хамгаалалттай бүс); 46-48-р Дүрэм (орон байраар хангахаас татгалзах); 55-56-р Дүрэм (хүмүүнлэгийн тусламжийг оруулах) болон 57-65-р Дүрэм (хуурч мэхлэх).

Протоколд тусламжийн үйл ажиллагаа явуулахын тулд холбогдох талуудын зөвшөөрлийг авсан байхыг шаарддаг⁵⁷ бол цугларсан практикийн ихэнхэд нь ийм шаардлага харагдахгүй байна. Гэсэн хэдий ч хүмүүнлэгийн байгууллага холбогдох талуудын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжгүй гэдэг нь ойлгомжтой юм. Харин ийм зөвшөөрлийг дур мэдэн олгохгүй байх нь зохисгүй юм. Хэрэв энгийн хүн ам өсгөлөнд нэрвэгдсэн үед хүмүүнлэгийн байгууллага тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр тусламж үзүүлэх боломжтой бол холбогдох тал нь зөвшөөрөл өгөх үүрэгтэй.⁵⁸ Хэдийгээр дур мэдэн зөвшөөрөл олгохоос татгалзаж болохгүй боловч практик дээр холбогдох тал нь тусламжийн ажиллагааг зохицуулах болон хүмүүнлэгийн тусламжийн ажилтнууд тухайн улсад нэвтрэхэд дагаж мөрдөх дотоодын хууль дүрэм, аюулгүй байдлын шаардлагуудыг хүндэтгэх ёстой гэж үздэг.

Цаашид тодруулах шаардлагатай асуудлууд

Судалгаагаар практик нь тодорхойгүй байгаа хэд хэдэн асуудлыг олж илрүүлсэн. Олон улсын зэвсэгт мөргөлдөөний хувьд “байлдагч”, “энгийн иргэн” зэрэг нэр томъёонуудыг тодорхойлсон байдаг бол олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний хувьд дайтах ажиллагааны зорилгоор зэвсэглэсэн эсэргүүцлийн бүлгийн гишүүдийг зэвсэгт хүчний гишүүн гэж үзэх үү эсвэл энгийн иргэн гэж үзэх үү гэдэг нь эргэлзээтэй байна. Ялангуяа, зэвсэглэсэн эсэргүүцлийн бүлгийн гишүүд нь дайтах ажиллагаанд шууд оролцоноор хамгаалалтаа алдсан энгийн иргэд үү эсвэл ийм бүлгийн гишүүд рүү довтолж болох уу гэдэг нь тодорхойгүй байна. Энэ тодорхойгүй байдал нь гэрээнд бас тусгагдсан байна. Жишээ нь: Нэмэлт II Протоколд “энгийн иргэд”, “энгийн хүн ам” гэсэн нэр томъёог хэд хэдэн зүйл заалтад хэрэглэсэн боловч тодорхойлолт өгөөгүй байна.⁵⁹ Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хамаарах удаах гэрээ хэлэлцээрүүдэд мөн л адил энгийн иргэд, энгийн хүн ам гэсэн нэр томъёог тодорхойлолгүйгээр хэрэглэсэн байна.⁶⁰

⁵⁷ Нэмэлт I Протокол, 70(1)-р зүйл, Нэмэлт II Протокол, 18(2)-р зүйлийг үз.

⁵⁸ Yves Sandoz, Christophe Swinarski, Bruno Zimmermann (eds.), Commentary on the Additional Protocols, ОУУЗХ, Женев, 1987 он, § 4885; § 2805-г үз

Олон улсын болон олон улсын бус шинжтэй зэвсэгт мөргөлдөөнд хамаарах өөр нэг тодорхойгүй асуудал бол “байлдаанд шууд оролцох” гэсэн нэр томъёоны тайлбар байхгүй байгаа явдал юм. Энгийн иргэн зэвсэг хэрэглэсэн эсвэл дайсан этгээд болон тэдний объектын эсрэг хүчирхийллийн үйлдэл хийснээр довтолгооны эсрэг хамгаалалтаа алдах нь тодорхой бөгөөд маргашгүй юм. Үүнтэй холбоотой ихэнх практикуудад хэрэг нэг бүрт үнэлгээ өгөх хэрэгтэй гэх эсвэл дайтах ажиллагаанд шууд оролцсон энгийн иргэд довтолгооноос хамгаалагдахгүй болно гэсэн ерөнхий дүрмийг давтсанаас бус “шууд оролцох” гэсэн үгийг тайлбарласан тохиолдол алга байна. Үүнээс урган гарч буй нэг асуудал бол эргэлзээтэй нөхцөл байдалд яах вэ гэсэн асуудал юм. Энэ үл ойлгогдох асуудлын улмаас, ОУУЗХ шууд оролцох гэсэн ойлголтыг тодорхой болгох үүднээс 2003 оноос эхлэн мэргэжилтнүүдийн уулзалтыг удаа дараа зохион байгуулсан.⁶¹

Довтолгооны үед пропорциональ байдлын зарчмыг хэрэглэх болон түүнийг хэрэглэх хүрээг тогтоох асуудал мөн л нээлттэй хэвээр байгаа юм. Судалгааны үр дүн энэ зарчмыг өргөн хүрээнд дэмжиж байгааг харуулсан болов ч энгийн иргэдийн амь нас сүйдэхийг цэргийн давуу байдлын эсрэг тэнцвэржүүлэх талаар гэрээний эрх зүй дэх зохицуулалтаас илүү тодорхой, нарийвчлан зохицуулсан зүйл алга байна.

Дайтах ажиллагаатай холбоотой зарим асуудлууд

Нэмэлт I болон II Протоколууд аюултай хүч агуулж буй барилга байгууламж руу довтлох нь тухайн бодис тархах шалтгаан болох, үүнээс үүдэн энгийн хүн амын дунд нөхөшгүй гарз хохирол учрах боломжтой бол холбогдох байгууламж руу довтлохыг хориглосон шинэ хэм хэмжээ оруулж ирсэн.⁶² Эдгээр хэм хэмжээ заншлын эрх зүйн нэг хэсэг болсон эсэх нь тодорхойгүй байгаа ч улс орнуудын практикаас үзвэл цэргийн төлөвлөгөө боловсруулахдаа ийм

⁵⁹ Нэмэлт II Протокол, 13-15-р зүйл ба 17-18-р зүйл.

⁶⁰ Тодорхой ердийн зэвсэгийг тухай конвенцын нэмэлт өөрчлөлт оруулсан II Протокол-г үз, 3(7)-(11)-р зүйл; Тодорхой Ердийн Зэвсэгийн тухай Конвенцын III Протокол, 2-р зүйл; Хүний эсрэг мина хэрэглэхийг хориглох тухай Оттавагийн конвенц, Оршил; Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм, 8(2)(e)(i),(iii) болон (viii).

⁶¹ Direct Participation in Hostilities under International Humanitarian Law, Олон улсын улаан загалмайн хорооноос бэлтгэсэн тайлан, Женев хот, 2003 оны 9 дүгээр сар, www.icrc.org-г үз.

байгууламж руу довтлох нь ноцтой үр дүнд хүргэх өндөр эрсдэлтэй болохыг анхаарч байсан нь харагддаг. Эдгээр улс орнууд ямар ч зэвсэгт мөргөлдөөний үед довтолгоонд орохдоо аюултай хүч алдагдсанаас энгийн хүн амын дунд нөхөшгүй гарз хохирол үүсэхээс сэргийлэхийн тулд онцгойлон анхаарах чухал болохыг хүлээн зөвшөөрч байгаа нь энэ шаардлага нь ямар ч зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэж болох олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ болсон болохыг харуулдаг.

Нэмэлт I Протоколд тусгагдсан өөр нэг шинэлэг зүйл бол байгаль орчинд өргөн хүрээг хамарсан, удаан хугацааны, ноцтой хор уршиг учруулах зорилгоор эсвэл тийм магадлал бүхий дайны арга зам, арга хэрэгслийг ашиглахыг хориглох тухай заалт юм. Нэмэлт I Протокол батлагдсанаас хойш зарим нэг улс орон энэ хориг нь цөмийн зэвсэгт хамаарахгүй тул цөмийн зэвсгийн хувьд ийм үүрэг хүлээхгүй гэдгээ удаа дараа мэдэгдэж байнаас үл хамааран энэ хоригийг улс орнууд маш их дэмжиж байсны үр дүнд заншлын эрх зүй болж чадсан.⁶³ Энэ тусгайлсан хэм хэмжээнээс гадна судалгааны үр дүнд байгаль орчин нь иргэний объект мөн тул бусад иргэний объектыг хамгаалах хэм хэмжээ, зарчмуудаар хамгаалагдсан гэж үздэг болон нь харагдсан. Ялангуяа ялгаатай хандах зарчим, proportionality болон довтолхоос өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагууд үүнд хамаарч байна. Энэ нь цэргийн объект биш бол байгаль орчинг довтолгооны объект болгож болохгүй бөгөөд аливаа цэргийн объект руу довтлох нь цэргийн тодорхой, шууд давуу байдал олж авахтай харьцуулахад хүрээлэн буй орчинд илүүтэй хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдолд довтолхыг хориглоно гэсэн үг юм. Nuclear Weapons case хэрэгт хийсэн зөвлөмжийн саналдаа Олон улсын шүүх “улс орон цэргийн зохистой объектыг тогтоохдоо хүрээлэн буй орчны асуудалд анхаарлаа хандуулах ёстой”⁶⁴ гэсэн байна. Мөргөлдөөнд оролцогч талууд ямар ч тохиолдолд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй хор хөнөөлийг багасгах талаар боломжтой бүх урьдчилсан сэргийлэх арга хэмжээг авах үүрэгтэй. Тодорхой

⁶² Нэмэлт I Протокол, 56(1)-р зүйл (2 дугаар догол мөрт нь хамаарахгүй тохиолдлын талаар тусгасан), Нэмэлт II Протокол, 15-р зүйл (хамаарахгүй тохиолдлын талаар тусгаагүй)

⁶³ Customary International Humanitarian Law, op. cit. (тэмдэглэл 4), боть I, 45-р Дүрэм

цэргийн ажиллагаанаас хүрээлэн буй орчинд учруулах хор хөнөөл, үр нөлөөний талаар шинжлэх ухааны нотолгоо байхгүй гэдэг нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүргээс мөргөлдөгч талуудыг чөлөөлж байгаа хэрэг биш юм.⁶⁵

Нэмэлт Протоколуудаар зохицуулагдаагүй асуудлууд байдаг. Жишээ нь: Нэмэлт Протоколуудад энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцогч хүмүүс болон объектыг хамгаалахтай холбоотой тодорхой зүйл заалт байдаггүй. Бодит байдал дээр эдгээр нь энгийн иргэд болон иргэний объектуудын адил довтолгооноос хамгаалагдсан байдаг. Улс орнуудын практикт бий болсон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр энгийн иргэд, иргэний объектод олгодогтой ижил нөхцөлд НҮБ-ын дүрмийн дагуу энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүс болон объектыг довтолхыг хориглосон хэм хэмжээ нь Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэмд тусгагдсан байна. Энэ нь одоо бүх төрлийн зэвсэгт мөргөлдөөнд хамаарах олон улсын эрх зүйн заншлын хэм хэмжээ болсон.⁶⁶

Дайтах ажиллагаатай холбоотой зарим асуудлыг Гаагийн зохицуулалтаар зохицуулагддаг. Эдгээр зохицуулалтыг удаан хугацааны турш олон улсын зэвсэгт мөргөлдөөний заншил гэж үзэж ирсэн.⁶⁷ Эдгээрээс зарим хэм хэмжээ нь олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний заншилаар хүлээн зөвшөөрөгдөх болсон. Жишээ нь: (1) цэргийн зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд дайсныхаа эд хөрөнгийг булаан авах эсвэл эвдэж сүйтгэхийг хориглох тухай болон (2) олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд ч мөн адил хамаарах дээрэм, тонуулыг хориглох тухай нэлээд эртний олон улсын заншлын эрх зүйн дүрэм журмууд байна. Дээрэм тонуул гэдэг нь дайсан этгээдийн хувийн өмчийн зүйлийг хувьдаа буюу өөртөө хэрэглэхээр хүчээр авахыг хэлнэ.⁶⁸ Дээрх хоригийн аль аль дайсны талын цэргийн тоног төхөөрөмжийг цэргийн олз гэж үздэг заншлын практикт хамаардаггүй.

Олон улсын заншлын эрх зүйн дагуу командлагчид нь харилцаа

⁶⁴ Олон Улсын Шүүх, *Legality of the Threat or Use of Nuclear Weapons*, op. cit. (тэмдэглэл 8), § 30.

⁶⁵ *Customary International Humanitarian Law*, op. cit. (тэмдэглэл 4), боть I, 44-р Дүрэм

⁶⁶ Мөн тэнд., 33-р Дүрэм.

⁶⁷ Нюрэнбургийн Олон улсын цэргийн үүүх, *Case of the Major War Criminas*, Шүүхийн шийдвэр, 10 дугаар сарын 1, 1946 он, *Official Documents*, Боть 1, х. 253-254.

холбооны ямар нэг аргаар хоорондоо холбоотой байж болох ба ийм холбоо харилцаа нь сайн санаан дээр үндэслэсэн байх ёстой. Бодит байдал дээр ийм холбоог *parlementaire* гэж нэрэлдэг зуучлагчаар дамжуулан хийдэг ба мөн утас болон радио зэрэг бусад төрлийн холбооны хэрэгслийг ашигладаг байна. *Parlementaire* гэдэг нь мөргөлдөөнд оролцогч аль нэг талаас нөгөө талтайгаа харилцах зорилгоор томилсон хүн бөгөөд халдашгүй эрхтэй байна. *Parlementaire* болохоо нөгөө талдаа мэдүүлэх зорилгоор цагаан туг барин явдаг уламжлалт арга нь одоог хүртэл хүчинтэй хэвээр байна. Түүнчлэн, талууд хамгаалагч улс, дундыг баримтлагч олон улсын хүмүүнлэгийн байгууллага, ОУУЗХ, бусад олон улсын байгууллага болон энхийг сахиулагч хүчин зэрэг гуравдагч этгээдэд хандан харилцаа холбоонд зуучлахыг уриалах практик байдаг. Цугларсан практикаас үзэхэд олон төрлийн байгууллага, институт олон улсын болон олон улсын бус шинэ чанартай зэвсэгт мөргөлдөөний үед хэлэлцээрийг зуучилж оролцсон байдаг бөгөөд энэ нь ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн юм. *Parlementaire*-г зохицуулж буй хэм хэмжээ Гаагийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд удаан хугацаанд олон улсын зэвсэгт мөргөлдөөний хувьд заншлын дүрэм гэж үздэг байсан. Сүүлийн 50 орчим жилийн туршлагаас үзвэл олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний хувьд ч заншлын хэм хэмжээ болсон байна.⁶⁹

Соёлын үнэт зүйлсийг хамгаалж байдаг хоёр төрлийн хууль тогтоомжийг практик судалгаагаар илрүүлсэн. Эхнийх нь Гаагийн зохицуулалтаас эхтэй ба цэргийн ажиллагааны үед цэргийн объектоос бусад шашин, урлаг, шинжлэх ухаан, боловсрол болон энэрэнгүй үйлсэд зориулсан барилга байгууламж, түүхийн хөшөө дурсгалд гэмтэл учруулахаас сэргийлж онцгойлон анхаарахыг шаарддаг. Мөн ийм барилга байгууламж, хөшөө дурсгалыг булаан авах, нурааж сүйтгэх, эсвэл санаатайгаар гэмтээхийг хориглодог. Эдгээр дүрмийг олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хамаарах заншлын эрх зүй гэж эртнээс үзэж ирсэн ч одоо бол олон улсын

⁶⁸ Олон Улсын эрүүгийн шүүхийн гэмт хэргийн элементүүдийг үз, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Дүрмийн дээрэм тонуул дайны гэмт хэрэг болох тухай (8(2)(b)(xvi)болон (e)(v)-р заалтууд).

⁶⁹ Customary International Humanitarian Law, *op. cit.* (тэмдэглэл 4), Боть 1, 67-69-р Дүрэм.

бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд ч хамаарах заншлын хэм хэмжээ мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон.

Хоёрдахь хууль нь “хүн бүрийн соёлын өвд их ач холбогдол бүхий үнэт зүйл”-ийг хамгаалж, соёлын үнэт зүйлд зүйл тусгай таних тэмдэгтэй байхаар зохицуулсан 1954 оны Соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенцын тодорхой зүйл заалтад үндэслэсэн. Цэргийн зайлшгүй шаардлагад үндэслээгүй бол соёлын үнэт зүйлсийг довтолохгүй байх, довтолгоонд өртөх нөхцлийг бүрдүүлэхгүй байхыг өнөөдрийн заншлын эрх зүй шаардаж байна. Мөн соёлын үнэт зүйлсийн эсрэг ямарваа сүйтгэх арга хэмжээ авахгүй байх, хулгай, дээрэм, тонуулын бүх хэлбэрийг хориглосон байна. Эдгээр хориглосон зохицуулалт нь Гаагийн конвенцоос эхтэй ба тус конвенц соёлын үнэт зүйлсийг хамгаалахтай холбоотой улс орнуудын практикт хэрхэн нөлөөлснийг харуулдаг.

Зэвсэг

Үлэмж хэмжээний гэмтэл, зовиур учруулах зэвсэг болон нэлд нь устгах шинж чанар бүхий зэвсгийг хориглох тухай ерөнхий зарчим нь бүх төрлийн зэвсэгт мөргөлдөөнд хамаарах заншил юм. Эдгээр зарчимд үндэслэн олон улсын заншлын эрх зүйд тодорхой төрлийн зэвсгийн хэрэглээг (буюу зарим төрлийн хэрэглээг) хориглох улс орнуудын практик бий болсон: хор болон хортой зэвсэг; биологийн зэвсэг, химийн зэвсэг; нулимс асгаруулагч хийг дайны арга хэрэгсэл болгон ашиглах; ургамал устгагч бодисыг дайнд ашиглах;⁷⁰ хүний биед ороод задардаг; хавтгай болдог сум; хүний биед ороод тэсэрч дэлбэрдэг сумыг хүний эсрэг хэрэглэх; анхдагч үр нөлөө нь хүний бие ороод рентгенээр олж харах боломжгүй жижиг хэлтэрхийгээр шархдуулах зэвсэг; иргэдийн анхаарлыг татахуйц объект болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тусгай хамгаалалтад буй хүмүүс болон объектод ямар нэг байдлаар холбоотойгоор бэлдсэн урхи занга; зөвхөн бүрэн сохлох чиг үүрэгтэй, эсвэл аль нэг чиг үүрэг нь сохлох зорилготой тусгайлан бүтээсэн лазерын зэвсэг.

⁷⁰ Энэ дүрэм нь биологийн болон химийн бодисыг хориглох; цэргийн объект бус ургамал руу довтолохыг хориглох; бодитой, олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой давуу байдалтай харьцуулахад энгийн хүн амын амь насыг хөнөөх, энгийн иргэдийг шархдуулах, иргэний объектуудад хохирол учруулах, эсхүл эдгээрийн аль нэгийг нь хамарсан асар их хохирол учруулсан довтолгоог хориглох; байгаль орчинд удаан хугацааны, ноцтой хохирол учруулахыг хориглох г.м. өөр бусад олон улсын заншлын хэм хэмжээтэй холбоотой байдаг. Мөн тэнд., 76-р Дүрэм

Заншлын хэм хэмжээгээр хориглогдоогүй зарим зэвсэгт тодорхой хязгаарлалт тогтоосон байдаг. Жишээ нь: газрын мина болон шатаах зэвсгүүд байна.

Газрын минийн нэлд нь устгах хор уршийг багасгах талаар онцгой анхаарах нь чухал. Үүнд жишээ нь: Мөргөлдөөнд оролцогч тал мина тавьсан газрынхаа байршлыг бүртгэх талаар боломжтой бүх арга хэмжээ авах тухай зарчим болно. Мөн мөргөлдөөний хурцадмал байдал намжсан үед газрын мина хэрэглэсэн мөргөлдөгч тал минийг зайлуулах, эсвэл энгийн иргэдэд аюулгүй болгох, эсвэл мина зайлуулах боломжоор хангах ёстой байдаг.

Оттавагийн конвенцыг 140 гаруй улс орон соёрхон баталж, цаашид соёрхон батлахаар төлөвлөж байгаа улс орнуудын олонхи нь хүний эсрэг газрын минийг үйлдвэрлэх, хураах, шилжүүлэх, хэрэглэхээ зогсоосон байна. Конвенцод нэгдэн ороогүй улс орнуудын практикаас шалтгаалан хориглосон хэм хэмжээ нь олон улсын заншлын эрх зүй болоогүй хэдий ч Оттавагийн конвенцод нэгдэн ороогүй улс орнууд, нэн даруй хориглох асуудлыг дэмижгүй байгаа улс орнуудыг оруулаад бараг бүх улсууд хүний эсрэг газрын мина хэрэглэх явдлыг цаашид бүрэн зогсоох нь зүйтэй гэдэг дээр санал нэгтэй байгаа юм.

Жагсаалаас гаргахын тулд илүү аюул багатай зэвсэг хэрэглэх боломжгүй байгаагаас бусад тохиолдолд шатаах зэвсэг хэрэглэхийг хориглодог. Энэ зэвсгийг хэрэглэсэн ямар ч тохиолдолд энгийн хүний амь насыг хөнөөх, энгийн иргэдийг шархдуулах, иргэний объектуудад хохирол учруулахаас сэргийлэх, хохиролыг багасгах талаар онгоц анхаарах нь чухал юм.

Эдгээр дүрэм журмын олонх нь эхэндээ олон улсын зэвсэгт мөргөлдөөнд үйлчилж байсан гэрээний зүйл заалтуудад тулгуурласан байна. Яваандаа энэ хандлага өөрчлөгсөн юм. Тухайлбал, олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хамаарах 1996 оны Тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох тухай 1996 оны конвенцын II Протоколд оруулсан нэмэлт өөрчлөлт, 2001 онд Тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох тухай конвенцын I-IV Протоколыг хэрэглэх хүрээг өргөжүүлж олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хамаарах тухай тус конвенцод оруулсан нэмэлт өөрчлөл зэрэг юм. Дээрх хориглох болон хязгаарлах заншлын хэм хэмжээг бүх төрлийн зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэж болох юм.

ОУУЗХ олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээг судлах үүрэг хүлээн авч байх үед Олон улсын шүүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүсэлтээр цөмийн зэвсгийн аюул заналхийлэл, хэрэглэх явдал хууль ёсны эсэх талаар зөвлөмж гаргах асуудлыг хэлэлцэж байсан юм. Тийм учраас ОУУЗХ энэ асуудлаар өөрсдөө дүн шинжилгээ хийхгүй байхаар шийдсэн. Олон улсын шүүх зөвлөмждөө “цөмийн зэвсгийн аюул заналхийлэл, цөмийн зэвсэг хэрэглэх явдал нь зэвсэгт мөргөлдөөнд хамаарах олон улсын эрх зүйн шаардлагад, ялангуяа олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх ёстой” гэжээ.⁷¹ Тодорхой тооны улс орон Нэмэлт I Протоколын талаар хэлэлцэж Протокол нь цөмийн зэвсгийн хэрэглээнд хамаарахгүй гэсэн байр суурьтай байгаа үед энэ дүгнэлт нь чухал ач холбогдолтой юм. Шүүхийн зөвлөмж нь дайтах ажиллагааны дүрэм журам, зэвсэг хэрэглэхэд хамаарах ерөнхий зарчмууд цөмийн зэвсгийн хэрэглээнд ч мөн адил хамаарна гэсэн утгатай. Эдгээр зарчим болон дүрэм журмыг хэрэглэх тухай шүүх цааш нь “цөмийн зэвсгийн аюул болон цөмийн зэвсэг хэрэглэх явдал нь зэвсэгт мөргөлдөөний олон улсын эрх зүйн хэм хэмжээнд харшлах төдийгүй хүмүүнлэгийн эрх зүйн зарчим хэм хэмжээнд ч харш юм” гэжээ.⁷²

Үндсэн Баталгаа

Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй, эсхүл оролцохоо больсон мөргөлдөгч талын мэдэлд байгаа бүх энгийн иргэд болон байлдааны ажиллагаанд оролцохоо больж жагсаалаас гарсан бүх хүмүүсийг үндсэн баталгаагаар хангах ёстой. Үндсэн баталгаа нь бүх хүмүүст хамаатай хэм хэмжээ учраас судалгаанд авч үзэхдээ хэсэг бүлэг хүмүүсийн хувьд ялгаж үзсэнгүй.

Эдгээр үндсэн баталгаанууд нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд суурилсан бөгөөд олон улсын зэвсэгт мөргөлдөөн болон олон улсын бус шинжтэй зэвсэгт мөргөлдөөнд хамаардаг. Судалгаанд үндсэн баталгаануудыг хүмүүнлэгийн эрх зүй уламжлалт хэллэгээр томъёолсоны учир нь энэ нь холбогдох заншлын хэм хэмжээг

⁷¹ Олон Улсын Шүүх, *Legality of the Threat or Use of Nuclear Weapons*, op. cit. (8), x. 226.

⁷² Мөн тэнд., НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 51 дэхь хуралдаан, Нэгдүгээр Хороо, Олон Улсын Улаан Загалмайн Хорооны Мэдэгдэл, UN Doc.A/C.1/51/PV.8, 10 дугаар сарын 18, 1996 он, х. 10, *International Review of the Red Cross*-т дахин хэвлэгдсэн, Дугаар. 316, 1997, хх. 118-119. (ОУУЗХ цөмийн зэвсгийн хэрэглэх явдал нь олон улсын эрх зүйд нийцүүлэхэд бэрх тухай мэдэгдсэн) .

бодитой тусгаж илэрхийлж байгаад оршино.⁷³ Тодорхой асуудлын тухай хэсэг бүлэг зүйл заалтын гол цөмийг нь тусгах замаар зарим хэм хэмжээг оруулсан. Эдгээрт, нөхөн төлбөр өгөлгүй албадан хөдөлмөрлүүлэх, хүчээр сураггүй алга болгох, дураар хорих, болон гэр бүлийн амьдралыг хүндэтгэх шаардлагын тухай хэм хэмжээ багтана.⁷⁴ Шаардлагатай үед олон улсын хүний эрхийн практикийг судалгаанд оруулсан ба ялангуяа, үндсэн эрхийн бүлэгт багтаасан болно. Тодорхой онцгой нөхцөл байдалд хүний эрхийн гэрээнүүдийг хүндэтгэхгүй тохиолдол гардаг боловч хүний эрхийн гэрээнүүдэд заасанчлан олон улсын хүний эрхийн хэм хэмжээ зэвсэгт мөргөлдөөний үед ч хамаардаг. Зэвсэгт мөргөлдөөний үед ч хүний эрхийн хэм хэмжээг хэрэглэсээр байдаг нь улс орнуудын практик, хүний эрхийн байгууллагууд болон Олон улсын шүүхээр баталгаажсан юм.⁷⁵ Саяхан Олон улсын шүүх Палестины булаан эзлэгдсэн нутаг дэвсгэрт хана босгож буй явдлын эрх зүйн үр дагаварын тухай зөвлөмж саналдаа “Хүний эрхийн конвенцуудаар олгогдсон хамгаалалт нь зэвсэгт мөргөлдөөний үед ч үйлчлэлээ алддаггүй” гээд зөвхөн олон улсын хүмүүлэгийн эрх зүй эсвэл зөвхөн олон улсын хүний эрхийн зохицуулах зүйлд хамаарах асуудлууд байж болох ч “Олон улсын эрх зүйн энэ хоёр салбарын аль алинд нь хамаарах асуудлууд байж болно”⁷⁶ гэжээ. Гэвч энэ судалгаагаар хүний эрхийн салбарын заншлыг олж тогтоох зорилго тавиагүй болно. Хүний эрхийн практикийг оруулсан нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн адил төстэй зарчмуудыг тодотгох, бэхжүүлэх, дэмжих зорилготой юм.

⁷³ Эдгээр дүрэмд энгийн иргэд болон жагсаалаас гарсан хүмүүст хүмүүнлэг, ялгаваргүй хандах холбоотой үндсэн баталгааг тусгасан: амыг нь хөнөөхийг хориглох; эрүү шүүлт тулгах, хэрцгий догшин харьцах, хувь хүний нэр хүндийг нь гутаан доромжлох, дайрч доромжлохыг хориглох; бие махбодыг зовоон тарчлаах ял ногдуулахыг хориглох; хүнд гэмтэл учруулах, эмнэлгийн эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтад оруулахыг хориглох; хүчиндэх болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрийг хориглох; боолчлол, боолын худалдааны бүх хэлбэрийг хориглох; барьцаанд авахыг хориглох; хүнийг бамбай болгон ашиглахыг хориглох; шударга шүүхийн баталгаа олгох, хамтын шийтгэл ногдуулахыг хориглох; энгийн иргэд болон жагсаалаас гарсан хүмүүсийн итгэл үнэмшил, шашны зан үйлийг хүндэтгэх шаардлага. Customary International Humanitarian Law, supra тэмдэглэл 4, Боть I, 87-94, 96-97 болон 100-104-р Дүрэм.

⁷⁴ Мөн тэнд., 95, 98-99 болон 105-р Дүрэм.

⁷⁵ Мөн тэнд., 32 дугаар бүлгийн танилцуулга, Үндсэн Баталгаа.

⁷⁶ Олон Улсын Шүүх, Legal Consequences of the Construction of a Wall in the Occupied Palestinian Territory, Зөвлөмж Санал, 7 дугаар сарын 9, 2004 он, § 106.

Хэрэгжилт

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэгжүүлэх тухай цөөнгүй хэм хэмжээ эдүгээ олон улсын заншлын эрх зүй болсон. Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн зэвсэгт хүчин болон өөрийнх нь удирдлага дор ажиллаж буй хүмүүс ба бүлэглэлүүд нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх, ийн хүндэтгэх явдлыг хангах ёстой. Зэвсэглэсэн эсэргүүцлийн бүлгийг оруулаад мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн зэвсэгт хүчиндээ олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн талаар заавар, зөвөлгөө өгөх ёстой. Эдгээр ерөнхий үүргээс гадна улс орны хувьд заавал биелэгдэх шинжтэй хэргэжилтийг хангах бусад механизмууд зэвсэглэсэн эсэргүүцлийн бүлгүүдэд хуулийн хүчинтэй үйлчлэх нь тодорхойгүй байна. Жишээ нь: улс орнууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх тухай өөрийн зэвсэгт хүчиндээ тушаал, зааварчилгаа өгөх нь олон улсын эрх зүйд тусгагдсан бол зэвсэгт эсэргүүцлийн бүлгийн хувьд тийм биш юм. Үүний нэгэн адил, улс орны хувьд шаардлагатай үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэглэх тухайд холбогдох түвшний цэргийн командлагчдад зөвөлгөө өгөх хуулийн зөвлөхтэй байх үүрэг хүлээдэг бол зэвсэгт эсэргүүцлийн бүлгийн хувьд ийм үүрэг хүлээдэггүй.

Түүнчлэн, улс орон өөрт хамаарах олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчилдөө хариуцлага хүлээж, зөрчлөөс үүдсэн хохирлыг бүрэн нөхөн төлөх үүрэгтэй байдаг. Зэвсэгт эсэргүүцлийн бүлгийн хувьд гишүүдийнхээ үйлдсэн зөрчлийн төлөө дээрхтэй адил төстэй хариуцлага хүлээх эсэх, хариуцлагын үр дагавар нь ямар байх нь тодорхойгүй байна. Дээр дурдсанчлан зэвсэгт эсэргүүцлийн бүлэг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэлж, “Хариуцлагатай ажиллах” ёстой.⁷⁷ Эндээс үзвэл зэвсэгт эсэргүүцлийн бүлэг нь бүлгийг бүрдүүлж буй хүмүүсийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээхээр байна. Гэвч энэ хариуцлагын үр дагавар нь тодорхойгүй байсаар байна. Олон улс оронд хохирогчид гэмт этгээдийн эсрэг шүүхэд зарга үүсгэх боломжтой боловч зэвсэгт эсэргүүцлийн бүлэг ямар хэмжээгээр хохирлыг бүрэн барагдуулах үүрэгтэй болох нь тодорхойгүй байна.

Хувь хүний хариуцлагын тухайд олон улсын хүмүүнлэгийн эрх

⁷⁷ Нэмэлт II Протокол, 1(1)-р зүйл.

зүйн заншлын дагуу дайны гэмт хэрэг үйлдсэн бүх этгээд, тушаал өгсөн эсвэл захирч байсан командлагч, дээд тушаалын этгээдэд хариуцлага тооцдог. Дайны гэмт хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагааг явуулах зэрэг хэрэгжилтийг улс орон хангах үүрэгтэй. Улс орон Олон улсын шүүх эсвэл холимог шүүх байгуулах замаар энэ үүргээс чөлөөлөгдөж болно.

Дүгнэлт

Судалгаагаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн бүх гэрээний зүйл заалтыг заншлын эрх зүй мөн эсэхийг тогтоохыг зориогүй бөгөөд харин тэдгээр асуудалд хамаарах улс орны практикт үндэслэн нэгтгэн дүгнэх замаар ямар олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээ байгаа болохыг олж тогтоохыг зорьсон. Судалгааны зарим нэг үр дүнгийн товч хураангуйгаас үзвэл гэрээний эрх зүйн хэм хэмжээ нь практикт өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж олон улсын заншлын хэм хэмжээ бүрэлдэхэд хүчтэй нөлөөлсөн болох нь харагдаж байна. Эдгээр зарчим болон хэм хэмжээний ихэнх нь одоо олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээ болсон билээ. Гэрээг соёрхон баталсан эсэхээс үл хамааран тэдгээр нь улс бүр дагаж мөрдөх ёстой эрх зүйн хэм хэмжээ болсон бөгөөд олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний бүх талуудад хамаарах хэм хэмжээний хувьд зэвсэгт эсэргүүцлийн бүлэгт ч бас хамаарах юм.

Олон улсын заншлын эрх зүйн олон хэм хэмжээ эдүгээ олон улсын болон олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний аль алинд нь үйлчилж байгаа бөгөөд улс орны практик нь гэрээний эрх зүйн хүрээнээс хальж олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд үйлчлэх хэм хэмжээг өргөжүүлсэн байна. Дайны ажиллагааны зохицуулалт болон дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед хүмүүст хандах хандлагын тухайд одоогийн гэрээний эрх зүйд үйлчилж байгаагаас илүү дэлгэрэнгүй болж чадсан. Хүмүүнлэгийн болон цэргийн үүднээс авч үзвэл эдгээр илүү дэлгэрэнгүй зохицуулалтууд нь энэ хэвээрээ хангалттай гэж үзэх үү эсвэл эрх зүйг цаашид хөгжүүлэх шаардлагатай юу гэдэг нь судлах асуудлын нэг юм.

Гэрээний эрх зүйн нэгэн адилаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын хэм хэмжээг түгээн дэлгэрүүлэх болон сургалт зохион байгуулах замаар хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр хэм

хэмжээг дотоодын хууль тогтоомж болон цэргийн гарын авлагад оруулж амжаагүй бол тусгах нь зүйтэй юм.

Судалгаагаар хууль тогтоомжид тодорхойгүй байгаа зарим асуудлыг гаргаж ирсэн бөгөөд олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний үед энгийн иргэд гэдэг нэр томъёоны тодорхойлолт, дайны ажиллагаанд шууд оролцох тухай ойлголт, proportionality зарчмын хэрэглээ болон хамрах хүрээ зэрэг цаашид тодотгох шаардлагатай асуудлыг тэмдэглэсэн байна.

Одоог хүртэл хүрсэн амжилт болон цаашид хийх шаардлагатай байгаа ажлыг харьцуулан үзвэл энэ судалгаа нь төгсгөл биш харин олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээ, зарчмын талаарх зөвшилцөл, ойлголцлыг илүү сайжруулахад чиглэсэн шинэ үйл ажиллагааны эхлэл гэж хэлж болно. Дээрх зорилгоор эрх зүйг хэрэгжүүлэх, илүү тодорхой нэг мөр болгох, хөгжүүлэх боломжийн талаархи цаашдын хэлэлцүүлэг, ярианы суурь нь энэ судалгааны ажил болох юм.

Хавсралт.

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн Заншлын Хэм Хэмжээний Жагсаалт

Энэ жагсаалтыг олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн заншлын тухай судалгааны I ботид орсон дүгнэлтүүдэд үндэслэн гаргав. Судалгаагаар олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн гэрээ бүрийн хэм хэмжээг заншлын эсэхийг тогтоохыг зориогүй учир хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнүүдийн бүтцийг дагахыг хичээсэнгүй. Хэм хэмжээнүүдийн хэрэглэх хүрээг дөрвөлжин хашилтад оруулав. ОУЗМ (IAC) гэсэн товчлол нь олон улсын зэвсэгт мөргөлдөөнд, ОУБШЧЗМ (NIAC) нь олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хамаарна. Сүүлийнх нь тохиолдолд зарим хэм хэмжээг “маргаантай” гэж тэмдэглэсний учир нь ерөнхий практик байгаа боловч хамрах хүрээ нь харьцангуй бага байсантай холбоотой.

Ялгаж Үзэх Зарчим

Энгийн иргэд болон байлдаж байгаа хүмүүсийн хоорондын ялгаа

- Дүрэм 1. Мөргөлдөгч талууд энгийн иргэд болон байлдаж байгаа хүмүүсийг цаг ямагт ялгаж үзэх нь чухал юм. Зөвхөн байлдаж байгаа хүмүүсийн эсрэг довтолж болно. Энгийн иргэдийн эсрэг довтолж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 2. Энгийн хүн амын дунд айдас төрүүлэх үндсэн зорилгоор хүчирхийлэл үйлдэх эсхүл хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 3. Эмнэлгийн болон шашны ажилтнаас бусад мөргөлдөгч талуудын зэвсэгт хүчний гишүүн бүр байлдаж буй хүн мөн. (ОУЗМ)
- Дүрэм 4. Мөргөлдөгч талын зэвсэгт хүчин гэдэг нь захирагдаж байгаа этгээдийнхээ үйлдлийн төлөө хариуцлага хүлээдэг, удирдлага, зохион байгуулалт бүхий бүх зэвсэгт хүчин, бүлэглэл, нэгжээс бүрдэнэ. (ОУЗМ)
- Дүрэм 5. Энгийн хүмүүс нь зэвсэгт хүчний гишүүн бус байна.

- Энгийн хүн ам нь бүх энгийн хүмүүсээс бүрдэнэ.
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 6. Дайны ажиллагаанд оролцоогүй энгийн хүмүүсийг довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Иргэний Объект болон Цэргийн Объектын хоорондын Ялгаа

- Дүрэм 7. Мөргөлдөгч талууд иргэний объект болон цэргийн объектуудыг үргэлж ялгаж үзэх ёстой. Дайралт нь зөвхөн цэргийн объект руу хийгдэж болно. Энгийн иргэдийн объект руу дайрахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 8. Мөн чанар, байрлал, зорилго, хэрэглээ зэрэг нь цэргийн ажиллагаанд үр нөлөө, дэмжлэг үзүүлэх ба бүхэлд нь болон хэсэгчлэн устгах, эзлэх, аюулгүй болгох нь тухайн цаг үе, нөхцөл байдалд цэргийн илт давуу байдал үүсгэх объектоор цэргийн объектыг хязгаарлаж ойлгоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 9. Цэргийн объектод хамаарахгүй бүх объектууд нь иргэний объект болно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 10. Цэргийн объектоор ашиглагдаагүй иргэний объектыг довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Үл ялгаварлан хийгдэх довтолгоо

- Дүрэм 11. Үл ялгаварлан хийгдэх довтолгоог хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 12. Үл ялгаварлан хийгдэх довтолгоо гэдэгт:
- (a) цэргийн тодорхой объект руу чиглээгүй довтолгоо;
 - (b) цэргийн тодорхой объект руу чиглээгүй дайны арга хэрэгсэл хэрэглэж буй довтолгоо;
 - (c) олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шаардлагын дагуу үр дагаварыг нь хязгаарлах боломжгүй дайны арга хэрэгсэл хэрэглэж буй довтолгоо;
- зэргийг хамааруулах ба эдгээр бүх тохиолдолд цэргийн объектууд болон энгийн иргэд, эсхүл иргэний объектуудыг ялгалгүй нэрвэгдүүлэх

довтолгоог хамруулна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Довтолгооны порпорциональ байдал

Дүрэм 13. Энгийн иргэд, эсхүл иргэний объектууд хот, тосгон буюу бусад бүсэд байгаа бие биеэсээ илэрхий тусгаарлагдмал бөгөөд ялгаж болох цэргийн хэсэг объектуудыг цэргийн ганц объект болгон аливаа арга хэрэгсэлээр бөмбөгдөх довтолгоог хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Довтолгооны үед авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Дүрэм 14. Энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектод тохиолдлын чанартай хохирол учруулах, эсхүл эдгээр нь хамтдаа олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар их хохирол учруулах нь илэрхий болбол уг довтолгоог хийхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 15. Цэргийн ажиллагаа явуулахдаа энгийн хүн ам, энгийн иргэд болон иргэний объектыг хамгаалах талаар байнга анхаарна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 16. Мөргөлдөгч талууд довтлох объект нь цэргийн объект мөн гэдгийг батлах талаар бололцоотой бүхнийг хийнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 17. Энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектуудад тохиолдлын чанартай хохирол учруулахаас зайлсхийх, аль болох бага хохирол учруулах үүднээс довтлох арга хэрэгслийг сонгохдоо урьдчилан сэргийлэх бололцоотой бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 18. Мөргөлдөгч талууд довтолгоо нь олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар илүү хохирол

- учруулах буюу энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектуудад тохиолдлын чанартай хохирол учруулах боломжтой эсэхийг үнэлэх талаар бололцоотой бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 19. Хэрэв довтолж буй объект нь цэргийн объект биш болох нь тодорхой болох, эсхүл довтолгоо нь олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар илүү хохирол учруулах буюу энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектуудад тохиолдлын чанартай хохирол учруулахаар бол мөргөлдөгч талууд довтолгоог зогсоох талаар бололцоотой бүх арга хэмжээг авах ёстой. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 20. Мөргөлдөгч талууд энгийн хүн амыг хамарч болзошгүй довтолгооны талаар боломжтой бүх нөхцөлд урьдчилан мэдэгдэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ) Цэргийн хэд хэдэн объектыг довтолоход адил хэмжээний цэргийн давуу байдал олж авах боломжтой байгаа тохиолдолд энгийн иргэдийн амь нас болон иргэний объектуудад хамгийн бага аюул учруулах объектыг сонгож авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)
- Дүрэм 21. Довтолгооны үр дагавраас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Дүрэм 22. Мөргөлдөгч талууд өөрсдийн хяналтад байгаа энгийн хүн ам, энгийн иргэд болон иргэний объектыг довтолгооны аюулаас хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 23. Мөргөлдөгч талууд хүн ам шигүү суурьшсан нутагт, эсхүл тэдгээрийн ойролцоо цэргийн объект байрлуулахаас аль болох зайлсхийнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)
- Дүрэм 24. Мөргөлдөөнд оролцогч тал бүр цэргийн объектын ойролцоо байрласан энгийн хүн ам, энгийн иргэд, болон иргэний объектыг цэргийн объектоос аль

болох холдуулан нүүлгэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)

Онцгой хамгаалалтад байгаа хүмүүс ба обьектууд

Эмнэлгийн болон шашны ажилтан ба обьектууд

- Дүрэм 25. Эмнэлгийн ажил үүргээ гүйцэтгэж байгаа эмнэлгйн ажилтныг ямар ч нөхцөлд хүндэтгэн хамгаална. Эмнэлгийн ажилтан хүмүүнлэгийн ажиллагаанаас хэтэрсэн, дайсагнасан үйл ажиллагаа явуулбал хамгаалалтаа алдана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 26. Эмнэлгийн ёс зүйн дагуу эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж байгаа, эсхүл эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж яваа хүнийг эмнэлгийн ёс зүйд харш үйлдэл хийхийг албадаж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Сэтгүүлчид

- Дүрэм 27. Шашны үүргээ гүйцэтгэж байгаа шашны ажилтныг бүх нөхцөлд хүндэтгэн хамгаална. Шашны ажилтан хүмүүнлэгийн ажиллагаанаас хэтэрсэн, дайсагнасан үйл ажиллагаа явуулбал хамгаалалтаа алдана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 28. Эмнэлгийн зорилгоор үүргээ гүйцэтгэж яваа эмнэлгийн албыг ямар ч үед хүндэтгэн хамгаална. Эмнэлгийн алба хүмүүнлэгийн ажиллагаанаас хэтэрсэн, дайсагнасан үйл ажиллагаа явуулбал хамгаалалтаа алдана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 29. Эмнэлгийн тээврийн үүргээ гүйцэтгэж буй эмнэлгийн тээврийн хэрэгслийг бүх нөхцөлд хүндэтгэн хамгаална. Эмнэлгийн тээврийн хэрэгсэл хүмүүнлэгийн ажиллагаанаас хэтэрсэн, дайсагнасан үйл ажиллагаа явуулбал хамгаалалтаа алдана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 30. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд нийцүүлэн Женевын конвенцын ялгах тэмдгийг зүүсэн

эмнэлгийн болон шашны ажилтан ба объектын эсрэг довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажиллагаанд оролцогч ажилтан ба объект

- Дүрэм 31. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажилтанг хүндэтгэн хамгаална. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 32. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажиллагаанд ашиглаж буй объектыг хүндэтгэн хамгаална. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй хүмүүс ба объект

- Дүрэм 33. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу энгийн иргэд болон иргэний обьектод олгодог хамгаалалтыг эдлэх эрх бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд заасны дагуу энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс болон объектын эсрэг довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Сэтгүүлчид

- Дүрэм 34. Зэвсэгт мөргөлдөөний бүсэд мэргэжлийнхээ дагуу аюултай томилолтоор ажиллаж байгаа бөгөөд дайтах ажиллагаанд шууд оролцоогүй сэтгүүлчдийг хүндэтгэн хамгаална. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Хамгаалагдсан бүс

- Дүрэм 35. Дайтах ажиллагааны аюулаас шархтан, өвчтөн болон энгийн иргэдийг халхлах зорилгоор байгуулсан бүсийн эсрэг довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 36. Талуудын хооронд хэлэлцэн тохирсон цэрэггүй бүс руу довтолгоогоо чиглүүлэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 37. Хамгаалалтгүй газар руу довтлохыг хориглоно.
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Соёлын үнэт зүйлс

Дүрэм 38. Мөргөлдөгч талууд соёлын үнэт зүйлсийг хүндэтгэн үзнэ:

А.Цэргийн ажиллагааны үед шашин, урлаг, шинжлэх ухаан, боловсрол эсхүл энэрэнгүйн зориулалт бүхий барилга байгууламж болон түүхийн хөшөө дурсгалыг эвдэж гэмтээхгүй байх талаар онцгойлон анхаарна.

В.Цэргийн зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд ард түмэн бүрийн соёлын өвд чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсийг довтолгооны объект болгохыг хориглоно.

(ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 39. Цэргийн зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд ард түмэн бүрийн соёлын өвд чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсэд устгах эсхүл түүнд хор хохирол учруулах байдлаар ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 40. Мөргөлдөөнд оролцогч талууд соёлын өмчийг хамгаална:

А.Шашин, энэрэхүйн үйлс, боловсрол, урлаг, шинжлэх ухааны зориулалт бүхий институт болон түүхийн хөшөө дурсгал, урлаг шинжлэх ухааны бүтээлд санаатайгаар гэм хор учруулах, устгаж сүйтгэх, булаан эзлэхийг хориглоно.

В.Ард түмэн бүрийн соёлын өвд чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсийг устгахад чиглэсэн аливаа үйлдэл болон тэдгээрийг шамшигдуулах хулгай, дээрэм тонуулын аливаа хэлбэрийг хориглоно.

(ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 41. Эзлэгч тал нь эзлэгдсэн нутаг дэвсгэрээс соёлын үнэт зүйлсийг хууль бусаар экспортлохоос урьдчилан сэргийлэх ба хууль бусаар эзлэгдсэн нутаг дэвсгэрээс экспортлогдсон соёлын үнэт

зүйлсийг буцаана. (ОУЗМ)

Аюултай хүч агуулсан төхөөрөмж болон байгууламж

Дүрэм 42. Усны далан хаалт, атомын цахилгаан станц зэрэг аюултай хүч агуулсан төхөөрөмж буюу байгууламж болон тэдгээрийн ойролцоо байгаа цэргийн бусад объектыг довтолсноор аюултай хүч алдагдаж энгийн хүн амд хүнд хохирол учруулахаас зайлсхийх талаар онцгойлон анхаарна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Байгаль орчны хамгаалалт

Дүрэм 43. Дайтах ажиллагааны үндсэн зарчмууд байгаль орчинд мөн хамаарна:

а. Цэргийн объект бус бол байгаль орчинд хохирол учруулахыг хориглоно.

б. Цэргийн зайлшгүй шаардлага байгаагаас бусад тохиолдолд байгал орчныг сүйтгэх, хор хохирол учруулахыг хориглоно. в. Байгаль орчинд хор хөнөөл учруулж болозошгүй цэргийн объект руу довтлох нь олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар их хохирол учруулахаар бол довтлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 44. Дайны арга хэрэгслийг ашиглахдаа түүний байгаль орчныг хамгаалах асуудлыг харгалзан үзнэ. Дайтах ажиллагааны үед байгаль орчинд тохиолдлын чанартай хохирлыг аль болох багасгах, зайлсхийх талаар боломжтой бүх арга хэмжээг авна. Тодорхой цэргийн ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар шинжлэх ухааны нотолгоо байхгүй гэдэг нь мөргөлдөгч талыг урьдчилан сэргийлэх арга хамжээ авах үүргээс чөлөөлөхгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)

Дүрэм 45. Байгаль орчинд удаан хугацааны, өргөн цар хүрээтэй, ноцтой хохирол учруулах дайны арга хэрэгсэлийг ашиглахыг хориглоно. Байгаль орчныг

сүйтгэх явдлыг зэвсэг болгон ашиглаж болохгүй.
(ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)

Дайны тодорхой арга хэрэгслүүд

Өршөөл үзүүлэхээс татгалзах

- Дүрэм 46. Хэнийг ч амьд үлдээхгүй байх тушаал өгөх, үүгээр эсрэг талаа сүрдүүлэх, эсхүл ийм үндсэн дээр байлдааны ажиллагаа явуулах тушаал өгөхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 47. Жагсаалаас гарсан этгээдийг довтлохыг хориглоно.
Аливаа дайтах үйлдлээс татгалзаж, оргон зайлахыг оролдоогүй хүмүүсийг дараах тохиолдолд жагсаалаас гарсанд тооцно:
а. Эсрэг талын мэдэлд байгаа хүнд;
б. Ухаангүй байгаа, шарх, эсхүл өвчний улмаас ямар нэг байдлаар жагсаалаас гарсан бөгөөд өөрийгөө хамгаалах чадваргүй болсон хүн;
в. Олзлогдох санаагаа илт илэрхийлж байгаа хүн;
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 48. Сүйрэлд орсон агаарын хөлгөөс бууж байгаа нэг ч хүн рүү газардах хүртэл нь довтолж болохгүй.
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Эд хөрөнгийг хураах ба устгах

- Дүрэм 49. Мөргөлдөгч талууд эсрэг талынхаа цэргийн тоног төхөөрөмжийг дайны олз болгон авч болно.
(ОУЗМ)
- Дүрэм 50. Цэргийн зайлшгүй шаардлага байгаагаас бусад тохиолдолд дайсныхаа эд зүйлсийг устгах, хураахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 51. Цэргийн зайлшгүй шаардлагаар эд хөрөнгийг хураах, устгах шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт:
(а)Цэргийн ажиллагаанд ашиглаж болох нийтийн хөдлөх өмчийг хураан авч болно.

(б)Нийтийн үл хөдлөх өмчийн хувьд узуфруктын хэм хэмжээг баримтална

(в) Хувийн өмчийг хүндэтгэн үзэж хурааж авч үл болно. (ОУЗМ)

Дүрэм 52. Дээрэм тонуул хийхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Өлсгөлөн болон хүмүүнлэгийн тусламжийг нэвтрүүлэх

Дүрэм 53. Энгийн хүн амын дунд өлсгөлөн бий болгож, түүнийг дайны арга хэрэгсэл болгохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 54. Энгийн хүн амыг аж төрөхөд шаардагдах объектыг довтлох, устгах, нүүлгэх, эхсүл хэрэгцээгүй болгохыг хориглоно.

Дүрэм 55. Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн хяналтад байгаа энгийн хүн амын аж төрөхөд зайлшгүй шаардагдах хүмүүнлэгийн тусламжийг ямар нэг ялгаваргүй, шударга хүргэх боломжоор хангаж чөлөөтэй, түргэн шуурхай нэвтрүүлнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 56. Мөргөлдөөнд оролцогч талууд зөвшөөрөл бүхий хүмүүнлэгийн тусламжийн ажилтныг чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор чөлөөтэй нэвтрэх боломжоор хангана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Хууран мэхлэх

Дүрэм 57. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчөөгүй дайны ов мэх хэрэглэхийг үл хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 58. Эвлрэх далбааг урвуулан ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 59. Женевын конвенцуудын ялгах тэмдгийг зүй бусаар ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 60. Нэгдсэн үндэстний байгууллагын ялгах тэмдэг, дүрэмт хувцсыг түүний зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

- Дүрэм 61. Бусад олон улсын хэмээнд хүлээн зөвшөөрсөн ялгах тэмдгийг зүй бусаар ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 62. Эсрэг талын далбаа, эсхүл цэргийн бэлгэ тэмдэг, цэргийн ялгах тэмдэг, эсхүл дүрэмт хувцсыг зэвсэгт мөргөлдөөний үед зүй бусаар ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)
- Дүрэм 63. Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсын далбаа, эсхүл цэргийн бэлгэ тэмдэг, эсхүл дүрэмт хувцсыг зэвсэгт мөргөлдөөний үед ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 64. Дайснаа гэнэдүүлэн довтолох зорилгоор байдлааныг зогсоох тухай хэлэлцээр байгуулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 65. Эсрэг талынхаа хүмүүсийг итгэл эвдэж хороох, шархдуулах, эсхүл олзлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дайсантай холбоо барих

- Дүрэм 66. Цэргийн командлагч нар харилцаа холбооны ямар ч хэрэгслийг ашиглан харилцаж болно. Ийм холбоо сайн санаа, итгэлцэл дээр үндэслэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 67. *Parlementaires* нар нь халдашгүй байна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 68. Коммандлагч нар *parlementaires* нар нь урьдчилан шийдвэр гаргахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 69. Эрх мэдлээ урвуулан ашиглаж олон улсын эрх зүйд харш, дайсандаа хохиролтой үйлдэл хийсэн *parlementaires* нь халдашгүй байдлаа алдана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Зэвсэг

Зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд

- Дүрэм 70. Үлэмж хэмжээний гэмтэл, зовиур учруулах дайны

- арга хэрэгсэл хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 71. Нэлд нь хөнөөх шинж чанартай зэвсэг хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 72. Хор болон хортой зэвсэг хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Биологийн зэвсэг

- Дүрэм 73. Биологийн зэвсэг хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Химийн зэвсэг

- Дүрэм 74. Химийн зэвсэг хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 75. Нулимас асгаруулагч хийг дайны хэрэгсэл болгон ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 76. Хогийн ургамал устгагч бодисыг дараах шинж чанартай бол дайны арга хэрэгсэл болгож хэрэглэхийг хориглоно.
- (а)Химийн зэвсгийн шинж чанартай;
 - (b)Биологийн зэвсгийн шинж чанартай;
 - (c)Цэргийн объект бус ургамалд чиглэсэн бол;
 - (d)олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар их хохирол учруулах буюу энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектуудад тохиолдлын чанартай хохирол учруулахаар бол; эсхүл
 - (e)байгаль орчинд өргөн хүрээг хамарсан, удаан хугацааны, хүнд хор хохирол учруулахаар бол.
- (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Задардаг сумнууд

- Дүрэм 77. Хүний биед ороод амархан задардаг эсхүл хавтгай болдог сумнуудыг ашиглахыг хориглоно. (ОУЗМ/

ОУБШЧЗМ)

Тэсэрч дэлбэрдэг сумнууд

Дүрэм 78. Хүний биед ороод тэсэрч дэлбэрдэг сумыг хүний эсрэг ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Илрүүлэх боломжгүй хэлтэрхийгээр шархдуулагч үндсэн үүрэг бүхий зэвсэг

Дүрэм 79. Хүний биед байхад нь рентгенээр олж илрүүлэх боломжгүй хэлтэрхийгээр шархдуулагч үндсэн чиг үүрэг бүхий зэвсэг ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Олзоор урхидах

Дүрэм 80. Энгийн иргэдийн анхаарлыг татахуйц объект болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тусгай хамгаалалтад буй хүмүүс болон объектод ямар нэг байдлаар холбоотойгоор бэлдсэн урхи занга хэрэглэхийг хориглоно. Иргэдийн анхаарлыг татахуйц объект болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тусгай хамгаалалтад буй хүмүүс болон объектод ямар нэг байдлаар холбоотойгоор бэлдсэн урхи занга; зөвхөн бүрэн сохлох чиг үүрэгтэй, эсвэл аль нэг чиг үүрэг нь сохлох зорилготой тусгайлан бүтээсэн лазерын зэвсэг. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Газрын Мина

Дүрэм 81. Газрын мина хэрэглэх үед нэлд нь устгах үр дагаврыг нь багасгах талаар онцгой анхаарна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 82. Газрын мина ашиглаж буй мөргөлдөгч тал мина тавьсан газрынхаа байршлыг бүртгэх боломжтой бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ маргаантай)

Дүрэм 83. Мөргөлдөөний хурцадмал байдал намжсан үед

газрын мина хэрэглэсэн мөргөлдөгч тал минийг зайлуулах, эсвэл энгийн иргэдэд аюулгүй болгох, эсвэл мина зайлуулах бололцоог бүрдүүлэх үүрэг хүлээнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Галдан Шатаах Зэвсэг

- Дүрэм 84. Галдан шатаах зэвсэгийг хэрэглэсэн ямар ч тохиолдолд энгийн хүний амь насыг хөнөөх, энгийн иргэдийг шархдуулах, иргэний объектуудад хохирол учруулахаас сэргийлэх, хохиролыг багасгах талаар онцгой анхаарах нь чухал юм. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 85. Жагсаалаас гаргахын тулд илүү аюул багатай зэвсэг хэрэглэх боломжгүй байгаагаас бусад тохиолдолд шатаах зэвсэг хэрэглэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Сохлогч Лазерын Зэвсэг

- Дүрэм 86. Зөвхөн бүрэн сохлох үндсэн чиг үүрэгтэй, эсвэл аль нэг чиг үүрэг нь сохлох зорилготой тусгайлан бүтээсэн лазерын зэвсэг ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Энгийн иргэд болон жагсаалаас гарсан хүмүүстэй харьцах

Үндсэн Баталгаа

- Дүрэм 87. Энгийн иргэд болон жагсаалаас гарсан хүмүүстэй хүнлэг харьцана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 88. Арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн эсхүл бусад үзэл бодол, үндэсний эсхүл нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал болон бусад статус, эсхүл эдгээртэй адилтгах бусад байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 89. Амийг хөнөөхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 90. Эрүү шүүлт тулгах, хэрцгий догшин харьцах,

- хувь хүний нэр хүндийг нь гутаах, түүнчлэн дайрч доромжлохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 91. Бие махбодыг зовоон тарчлаах ял ногдуулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 92. Хүнд гэмтэл учруулах, эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтад оруулах эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлгийн стандартад нийцээгүй, тухайн хүний эрүүл мэндийн байдалтай холбоогүй ямар нэг эмнэлгийн ажиллагаанд оруулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 93. Хүчиндэх болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 94. Боолчлол болон боолын худалдааны бүх хэлбэрийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 95. Хөлсгүй эсхүл хүчээр хөдөлмөрлүүлэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 96. Хүн барьцаалахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 97. Хүнийг бамбай болгон ашиглахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 98. Хүчээр сураггүй алга болгохыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 99. Дур мэдэн эрх чөлөөг хязгаарлахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 100. Баталгаатай шударга шүүхээр хэргээ шийдүүлэхээс бусад тохиолдолд хэнийг ч буруутай гэж үзэх эсхүл хэнд ч ял шийтгэл ногдуулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 101. Хэнийг ч хэрэг үйлдэх үеийн үндэсний болон олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогддоггүй байсан үйлдэл, эс үйлдлийнх нь төлөө гэмт хэрэгт холбогдуулан буруутгаж, яллах эсхүл гэмт хэргийг үйлдэх үед ногдуулж байсан шийтгэлээс нь илүү хатуу ял ногдуулж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 102. Аливаа хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүйгээр шийтгэж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 103. Хамтын шийтгэл ногдуулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

- Дүрэм 104. Энгийн иргэд болон жагсаалаас гарсан хүмүүсийн итгэл үнэмшил, шашны зан үйлийг хүндэтгэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 105. Гэр бүлийн амьдралыг хүндэтгэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Байлдаж Байгаа Хүмүүсийн Болон Дайнд Оролцогчдын Эрх Зүйн Байдал

- Дүрэм 106. Байлдаж байгаа хүмүүс довтолгоонд эсхүл түүнд бэлтгэж байгаа цэргийн ажиллагаанд оролцох үедээ өөрсдийгөө энгийн хүн амаас ялгах үүрэгтэй. Хэрэв ийнхүү ялгаж чадахгүй бол дайнд олзлогдогчдын эрхийг эдлэхгүй. (ОУЗМ)
- Дүрэм 107. Тагнуул хийж яваад олзлогдсон байлдаж байгаа хүн дайнд олзлогдогчийн эрх эдлэхгүй. Шүүн таслах үйл ажиллагаа явуулалгүйгээр тэднийг буруутгах, яллаж болохгүй. (ОУЗМ)
- Дүрэм 108. Нэмэлт I Протоколын дагуу хөлсний этгээд нь байдлаж байгаа хүмүүс болон дайнд олзлогдогчийн эрхийг эдлэхгүй. Тэднийг урьдчилан шүүн таслах ажиллагаа явуулалгүйгээр буруутгах, яллаж болохгүй. (ОУЗМ)

Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд

- Дүрэм 109. Шаардлагатай нөхцөл байдал бий болмогц, ялангуяа дайтах идэвхтэй үйл ажиллагаа зогссоны дараа мөргөлдөгч талууд шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгсдийг эрж хайх, цуглуулж, нүүлгэх ажлыг ямар нэг ялгаваралгүйгээр хийнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 110. Шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд тэдний эрүүл мэндийн байдал шаардаж байгаа тохиолдолд эмнэлгийн тусламж, асрамжийг аль болох түргэн хугацаанд бүрэн хэмжээгээр үзүүлнэ. Эмнэлгийн бус өөр ямар нэг

- шалтгаанаар тэдэнд ялгавартай хандаж болохгүй.
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 111. Дүрэм 111. Мөргөлдөөнд оролцогч талууд шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөдтэй зохисгүй харьцах, тэдний хувийн өмч хөрөнгийг дээрэм, тонуулаас хамгаалах талаар бололцоотой бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Амь үрэгдэгсэд

- Дүрэм 112. Шаардлагатай нөхцөл байдал бий болмогц, ялангуяа дайтах үйл ажиллагаа зогссоны дараа мөргөлдөөн оролцогч тал амь үрэгдсэн хүмүүсийг аль болох яаралтай эрэн сурвалжлах, цуглуулах, нүүлгэн шилжүүлэх талаар бололцоотой бүх арга хэмжээг ямар нэг ялгаварлалгүйгээр авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 113. Мөргөлдөөн оролцогч талууд амь үрэгдэгсдийн цогцсыг дээрэм тонуулд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар бололцоотой бүх арга хэмжээг авна. Амь үрэгдэгсдийн цогцост хүнд гэмтэл учруулахыг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 114. Мөргөлдөөнд оролцогч талууд амь үрэгдсэн хүмүүсийн цогцсыг холбогдох талын хүсэлтээр буцаах, эсхүл төрөл төрөгсдийн нь хүсэлтээр буцаахад туслах үүрэгтэй. Тэдний хувийн эд хогшлыг нь мөн буцаана. (ОУЗМ)
- Дүрэм 115. Амь үрэгдсэн хүмүүсийг хүндэтгэлтэйгээр оршуулах бөгөөд тэдний булшийг хүндэтгэн арчлан хамгаална. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 116. Амь үрэгдсэн хүмүүсийг тогтоохын тулд мөргөлдөгч талууд тэдгээрийг оршуулахаасаа өмнө байгаа бүх мэдээллийг бүртгэж авах бөгөөд оршуулгын газрын байршлыг тэмдэглэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Сураггүй алга бологсод

- Дүрэм 117. Мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагааны

улмаас сураггүй болсон гэж мэдээлсэн хүмүүсийг эрэн сурвалжлах талаар бололцоотой бүх арга хэмжээг авах болон тэдний гэр бүлд эдгээр хүмүүстэй холбогдох бүхий л мэдээллийг өгнө. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээд

- Дүрэм 118. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг шаардлагатай хоол хүнс, ус, хувцас хэрэглэл, орон байр болон эмнэлгийн тусламжаар хангана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 119. Эрх чөлөөгөө хасуулсан нэг гэр бүлийн эрэгтэй, эмэгтэйг хамт байлгах аас бусад тохиолдолд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусад нь байрлуулж, эмэгтэй хүний шууд хяналтын дор байлгана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 120. Эрх чөлөөгөө хасуулсан хүүхдийг гэр бүлтэй нь хамт байлгах аас бусад тохиолдолд насанд хүрэгчдээс тусад нь байрлуулна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 121. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг тулалдааны талбараас холдуулж эрүүл ахуйн шаардлага хангасан байранд байлгана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 122. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хувийн эд зүйлсийг тонож дээрэмдэхийг хориглоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 123. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн тухай мэдээллийг бүртгэж авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 124. А.Олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хоригдож буй нөхцөл байдлыг шинжих, тэдэнд гэр бүлтэйгээ холбоо барих боломж олгохын тулд ОУУЗХ-д эдгээр хүмүүстэй тогтмол уулзах боломж олгоно. (ОУЗМ)
Б.Олон улсын бус шинжтэй зэвсэгт мөргөлдөөний үед ОУУЗХ мөргөлдөөнтэй холбогдуулан эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй уулзах тэдний хоригдож буй нөхцөл байдлыг шинжих, тэдэнд гэр бүлтэйгээ холбоо барих боломж олгох зорилгоор

- мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно. (ОУБШЧЗМ)
- Дүрэм 125. Холбогдох албаны хүмүүсийн хяналтын дор боломжийн давтамжтай хугацаанд эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст өөрийн гэр бүлтэйгээ харилцах боломж олгоно. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 126. Олон улсын бус шинжтэй зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс болон эрх чөлөөгөө хасуулсан энгийн иргэдийг боломжтой тохиолдолд тэднийг эргэж ирж буй хүмүүстэй уулзуулах, ялангуяа ойрын хамаатан садантай нь уулзуулах зөвшөөрөл олгох. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 127. Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хувийн итгэл үнэмшил болон шашны зан үйлийг хүндэтгэж үзнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 128. А.Дайтах идэвхтэй ажиллагаа зогссоны дараа дайнд олзлогдогчидыг аль болох удаалгүйгээр суллах болон эх оронд нь буцаана. (ОУЗМ)
Б.Эрх чөлөөгөө хасуулсан энгийн иргэдийн эрх чөлөөг нь хязгаарлах шалтгаан нөхцөл нь үгүй болсон тохиолдолд болон арга ядахад дайтах идэвхтэй ажиллагаа зогссоны дараа аль болох түргэн суллана. (ОУЗМ)
В.Олон улсын бус шинжтэй зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрх чөлөөг хязгаарлах болсон шалтгаан нь үгүй болмогц аль болох түргэн суллана. (ОУБШЧЗМ)
Эдгээр хүмүүсийн хэргийг шийдэх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдаж байгаа болон хуулийн дагуу ял эдэлж байгаа бол эрх чөлөөг нь үргэлжлүүлэн хязгаарлаж болно.

Нүүлгэн шилжүүлэх ба нүүлгэн шилжсэн хүмүүс

- Дүрэм 129. А.Цэргийн зайлшгүй шаардлага байгаа болон тухайн энгийн иргэдийн аюулгүй байдалтай холбоотойгоос бусад үед олон улсын зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал эзлэгдсэн нутаг дэвсгэрийн энгийн хүн амыг

- нутаг дэвсгэрээ бүхэлд нь болон хэсэгчлэн орхиж явахыг албадан тулган хүлээлгэх буюу хүчээр нүүлгэн шилжүүлж болохгүй. (ОУЗМ)
- Б.Цэргийн зайлшгүй шаардлага байгаа болон тухайн энгийн иргэдийн аюулгүй байдалтай холбоотойгоос бусад үед олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал мөргөлдөөнтэй холбогдуулан энгийн хүн амыг бүрмөсөн болон хэсэгчлэн нүүлгэн шилжүүлэх болохгүй. (ОУБШЧЗМ)
- Дүрэм 130. Улс орон эзлэгдсэн нутаг дэвсгэрт өөрийн хүн амын тодорхой хэсгийг шилжүүлэх буюу нүүлгэхийг хориглоно. (ОУЗМ)
- Дүрэм 131. Нүүлгэх шаардлагатай үед энгийн иргэдийг гэр бүлээс нь салгалгүйгээр шаардлага хангасан эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдал, хүнс тэжээл ба орон байрны нөхцөл бүрдүүлэх талаар боломжтой бүх арга хэмжээг авна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 132. Нүүлгэн шилжүүлэх болсон шалтгаан нөхцөл нь үгүй болсон үед ийнхүү шилжсэн хүмүүс өөрийн гэр орон болон байнга оршин суудаг газартаа сайн дурын үндсэн дээр аюулгүйгээр буцаж очих эрхтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 133. Нүүлгэн шилжсэн хүмүүсийн өмчийн эрхийг хүндэтгэнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Онцгой хамгаалалтад авах бусад хүмүүс

- Дүрэм 134. Зэвсэгт мөргөлдөөнд өртсөн эмэгтэйчүүдийн эрүүл ахуй, тусламж, хамгаалалттай холбоотой хэрэгцээг хүндэтгэж үзнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 135. Зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдүүдийг тусгайлан хүндэтгэж, хамгаална. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 136. Хүүхдийг зэвсэгт хүчин болон зэвсэгт бүлэглэлд элсүүлж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 137. Хүүхдийг дайтах ажиллагаанд оролцохыг зөвшөөрч болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 138. Зэвсэгт мөргөлдөөнд өртсөн өндөр настан, хөгжлийн

бэрхшээлтэй иргэд тусгай хүндлэл, хамгаалалтад байх эрхтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Хэрэгжилт

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг Дагаж Мөрдөх

- Дүрэм 139. Мөргөлдөөнд оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх ба өөрийн зэвсэгт хүчин болон өөрийнх нь захиргаанд байгаа буюу удирдлага, зааварчилгааг дагаж буй бусад хүмүүс эсхүл бүлэглэлүүд нь олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх явдлыг хангана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 140. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх, хүндэтгэх явдлыг хангах үүрэг нь адил хандах зарчимд тулгуурлаж болохгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 141. Улс бүр шаардлагатай үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэглэх талаар цэргийн дарга нарт зохих түвшинд зөвлөгөө өгч байх хуулийн зөвлөхтэй байна. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 142. Улс орон болон мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн талаар заавар өгнө. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 143. Улс орон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн номлолыг энгийн хүм амд сургах ажлыг дэмжих үүрэгтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг Сахиулах

- Дүрэм 144. Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөн үйлдлийг улс орнууд дэмжиж болохгүй. Улс орнууд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлийг зогсоохын тулд боллоцооны хэрээр нөлөөлөхийг чармайх үүрэгтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 145. Олон улсын эрх зүйн дагуу хориглоогүй тохиолдолд дайтагч талууд зөвхөн тодорхой нөхцөлд өширхөн халдаж болно. (ОУЗМ)

- Дүрэм 146. Дайтагч талууд нь Женевын конвенцуудаар хамгаалагдсан хүмүүсийн эсрэг өширхөн халдлага хийхийг хориглоно. (ОУЗМ)
- Дүрэм 147. Женевын Конвенцууд болон Соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенцын дагуу хамгаалагдсан объект руу өширхөн довтлохыг хориглоно. (ОУЗМ)
- Дүрэм 148. Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд өширхөн довтлох эрхгүй байна. Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй эсхүл оролцохоо больсон хүмүүсийн эсрэг бусад эсрэг арга хэмжээ авахыг хориглоно. (ОУБШЧЗМ)

Хариуцлага ба Нөхөн Төлбөр

- Дүрэм 149. Доорхыг оруулаад өөрт хамаарах олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зөрчилд улс орсон хариуцлага хүлээнэ:
(a) Зэвсэгт хүчний горуулаад өөрийн байгууллагуудын үйлдсэн зөрчил;
(b) Засгийн эрхийн зарим хэсгийг хэрэгжүүлэх эрх олгогдсон хүн болон аж ахуйн нэгжийн үйлдсэн зөрчил;
(c) Өөрийнх нь шууд удирдлага, захирамжийн дагуу ажиллаж буй эсхүл зааврынх нь дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хүн эсхүл бүлэглэлийн үйлдсэн зөрчил; болон
(d) Хувь хүн болон бүлэглэлийн үйлдсэн зөрчлийг өөрийн үйлдэл хэмээн хүлээн зөвшөөрсөн бол;
(ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 150. Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн зөрчилд орсон улс орон зөрчлөөс үүдсэн хохирлыг бүрэн нөхөн төлөх ёстой. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Хувь Хүний Хүлээх Хариуцлага

- Дүрэм 151. Хувь хүмүүс нь өөрсдийн үйлдсэн дайны гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

- Дүрэм 152. Цэргийн дарга нар болон удирдах албан тушаалтан өөрийн өгсөн тушаал зааврын дагуу үйлдэгдсэн дайны гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 153. Гэмт хэргийг үйлдэж байгаа, эсхүл үйлдэх гэж завдаж байгааг мэдэж байсан буюу мэдэх бололцоотой байсан эсэхээс шалтгаалан зөрчлийг сэрэмжлэн зайлуулах буюу таслан зогсоох талаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд шаардлагатай бүх арга хэмжээг аваагүй эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгэж хариуцлага тооцоогүй цэргийн дарга нар болон бусад удирдах албан тушаалтан захирагдаж буй этгээдийн үйлдсэн дайны гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээнэ. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 154. Байлдаж байгаа хүн бүр илт хууль бус тушаалыг биелүүлэхгүй байх үүрэгтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 155. Удирдах албан тушаалтны тушаалаар хийх үйлдэл нь хууль бус гэдгийг мэдэж байсан эсхүл тухайн үйлдлийн илт хууль бус мөн чанараас шалтгаалж мэдэх ёстой байсан бол захирагдаж буй этгээд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дайны Гэмт Хэрэг

- Дүрэм 156. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчих нь дайны гэмт хэрэг мөн. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 157. Улс орон дайны гэмт хэрэгт үндэсний шүүхийн түгээмэл харьяалал тогтоох эрхтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 158. Улс орон өөрийн үндэсний хүн болон зэвсэгт хүчний үйлдсэн эсхүл өөрийнх нь нутаг дэвсгэр дээр санаатай үйлдсэн дайны гэмт хэргийг мөрдөн байцааж, шаардлагатай бол сэжигтэнг шүүж болно. Тэд мөн өөрийн шүүхийн харьяалалд хамаарах бусад дайны гэмт хэргийг мөрдөн байцааж, зохистой тохиолдолд шүүх эрхтэй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)
- Дүрэм 159. Зэвсэгт мөргөлдөөн дуусах үед Засгийн эрхийг

барьж байгаа этгээд дайны гэмт хэргийн сэжигтэн болон ялтнаас бусад олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцсон хүмүүс болон зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст боломжтой хамгийн өргөн хүрээнд өршөөл үзүүлэхийг хичээх үүрэгтэй. (ОУБШЧЗМ)

Дүрэм 160. Хязгаарлалт тогтоох тухай хууль тогтоомж дайны гэмт хэрэгт хамаарахгүй. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

Дүрэм 161. Дайны гэмт хэргийг мөрдөн байцаах, сэжигтэнг шүүх боломжийг хангахын тулд улс орнууд боломжтой бүх хүрээнд хамтран ажиллах тухайд хүчин чармайлт гаргана. (ОУЗМ/ ОУБШЧЗМ)

INTERNATIONAL REVIEW of the Red Cross

Олон Улсын Улаан Загалмайн Сэтгүүл

Энэ сэтгүүл англи хэл дээр жилд дөрвөн удаа буюу 3, 6, 9, 12 дугаар саруудад хэвлэгддэг.

Жил бүр сонгомол нийтлэлүүд бүсийн хэмжээнд Араб, Хятад, Франц, Орос, Испани хэлээр хэвлэгддэг билээ.

Сэтгүүлд нийтлэгдсэн нийтлэлүүдийг дараах интернет хуудаснаас үнэгүй үзэж болно.

www.icrc.org/eng/review

Нийтлэл хүлээн авах тухай

Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, бодлого болон үйл ажиллагаатай холбоотой сэдвээр нийтлэл хүлээн авч байна. Ихэнх дугаарууд Редакцийн Зөвлөлийн шийдвэрээр тодорхой сэдвээр гардаг ба сэтгүүлийн цахим хуудас дээр Ирээдүйн Сэдэв гэсэн гарчигтай хэсгээс энэ талаар үзэж болно. Ялангуяа тэнд байгаа сэдвээр ирүүлэх нийтлэлийг талархан хүлээн авах болно.

Нийтлэлийг Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэлээр хүлээн авна. Шаардлагатай бол сонгогдсон нийтлэлийг англи хэл рүү орчуулна.

Ирүүлэх нийтлэл нь өөр сэтгүүлд илгээсэн, хэвлэгдсэн эсхүл хаа нэгтээ хэвлэхээр хүлээн авсан байж болохгүй. Нийтлэлийг хамтаар хэлэлцэн сонгох ба эцсийн шийдвэрийг Ерөнхий Редактор гаргана. Тус сэтгүүл нь нийтлэлийг засварлах эрх эдэлнэ. Нийтлэлийг хүлээн авснаас дөрвөн долоо хоногийн дотор хүлээн авах, татгалзах, болон засвар хийлгэхээр буцаах тухай хариу явуулна. Ирүүлсэн нийтлэлийн хувийг буцааж зохиогчид илгээхгүй болно.

Нийтлэлийг доорх электрон шуудангаар илгээнэ үү.
review.gva.@icrc.org

Нийтлэлд тавигдах шаардлага

Нийтлэл 5000-аас 10000 үгтэй байна. Үүнээс бага хэмжээний нийтлэлийг Тэмдэглэл ба Санал гэсэн хэсэгт хэвлэнэ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү:
www.icrc.org/eng/review

Захиалга

Хэвлэх тоо нь хязгаарлагдмал бөгөөд сэтгүүлийг тодорхой тооны сонгогдсон институт болон байгууллагуудад тараадаг. Сэтгүүлийн олдоцоос хамаарч өөр газруудад түгээж болно.

Дараах хаягаар сэтгүүлийг захиалж болно:

International Committee of the Red Cross (ICRC)
Production, Multimedia and Distribution 19,
Avenue de la Paix, CH-1202 Geneva, Switzerland
f +41 22 730 27 68,
e-mail: shop.gva@icrc.org
www.icrc.org/eng/shop

©icrc

Тус сэтгүүлд нийтлэгдсэн материалыг дахин хэвлэх, нийтлэх зөвшөөрлийг Ерөнхий Редактораас авна. Хүсэлтийг Редакцийн Зөвлөлд илгээнэ үү.

Редакцийн Зөвлөл

Ерөнхий редактор: Тони Пфаннер
Редакторын туслах: Робин Гэйс
Хэвлэлийн туслах: Марианэ Переда

International Review of the Red Cross
19, Avenue de la Paix
CH -1202 Geneva, Switzerland
t +41 22 734 60 01
f +41 22 733 20 57

ОУУЗХ

Зүүн Бүсийн Төлөөлөгчийн Газар
Qijiyuan Diplomatic Compound B2
Jianguomenwai Dajie 9
Бээжин 100600, Хятад
Утас: +86 10 85323290
Факс: +86 10 65320633
Имейл: beijing.bej@icrc.org

Volume 87 Number 857 March 2005

INTERNATIONAL **REVIEW** of the Red Cross



ICRC

www.icrc.org/eng/review

2008.06 100